

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс



Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төлөв байдал

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

2005 он



АГУУЛГА

Товчилсон үгсийн тайлбар

Удиртгал

Хүүхдийн талаарх орчин үеийн хандлага
Монголын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал
Гүйцэтгэлийн хураангуй

3-5

Нэгдүгээр бүлэг

- 1.1. Судалгааны арга зүй
- 1.2. Хамрах хүрээ

6-8

Хоёрдугаар бүлэг

- 2.1. **Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлын эрхзүйн орчин**
- 2.2. Олон улсын гэрээ конвенци
- 2.3. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид тусгасан байдал
- 2.4. Үндэсний бодлого хөтөлбөрт тусгагдсан байдал

9-17

Гуравдугаар бүлэг

3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрэх хэлбэрүүд, Монгол улсад судлагдсан байдал энэ асуудалтай тэмцэж буй нийгэм -эрхзүйн орчин
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт
- 3.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай үндсэн ойлголт
- 3.2. Төрийн болон ТББ - уудын хэсэгчилсэн судалгаануудаас хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрэх хэлбэрүүдийг гаргасан үзүүлэлтүүд
- 3.3. Хүүхдэд нийгэм- эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас сурвалжилсан албан ёсны тоо баримт, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

8 -35

Дөрөвдүгээр бүлэг

- 4 Энэ хүрээнд цуглуулсан мэдээ, мэдээлэл, тоо баримтад тулгуурласан дүгнэлт санал

35-47

Хавсралтууд

© Хүний Эрхийн Үндэсний Комисс

Судалгааны тайланг гүйцэтгэсэн үндэсний зөвлөх С. Баасанбат



Товчилсон үгсийн тайлбар

АХИС	Английн хүүхдийг ивээх сан
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
ГХ	Гэмт хэрэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДОХ	Дархлал олдмол хам шинж
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦОНХХ	Цагдаа олон нийт хариуцсан хэлтэс
НХХ	Насанд хүрээгүй хүн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НХХЯ	Нийгмийн хөдөлмөр хамгааллын яам
МХЭТ	Монголын хүүхдийн эрхийн төв
ШШБЕГ	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
МХЭТ	Монголын хүүхдийн эрхийн төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенци
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЯГБХУТК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах тухай бүх хэлбэрийг устгах тухай конвенци
UNIFEM	НҮБ - ын эмэгтэйчүүдийн сан

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



УДИРТГАЛ

Хүүхэд бол "бүрэн бүтэн" хүн мөн. Тэдний өөрийн гэсэн бие сэтгэл, ухаан бодол нь нийгэмтэйгээ салшгүй холбоотойгоор хөгжиж байдаг билээ. Гэтэл хүүхдийг судлахдаа танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдар, сэтгэлзүй гэх мэт тодорхой нэг талыг ангилан хувааж авч үздэгээс ганц нэгэн асуудалд төвлөрсөн судалгааны ажил болон хөтөлбөрүүд хэрэгждэг байна. Ингэснээр хүүхдийн хөгжлийн талаарх үзэл хандлагууд хоорондоо зөрчилдөх, өрөөсгөл дүгнэлтэнд хүрэх, тэднийг дутуу үнэлэх, буруу ойлгох зэрэг бэрхшээл учирдаг тул хүний хүүхэд насны амьдралын мөчлөгийг хувь хүн, гэр бүл, олон нийт, нийгмийн хүрээнд холбон авч үзэхийг энэ цаг үе бидэнд *хэлж* байна. Өнөө үед хүүхдийн асуудлыг олон талаас нь авч үзэж, хэрэгцээг нь бүхлээр харах хандлага бий болж, тэдний хүрээлэн буй нийгмийн орчныг эрүүлжүүлэх дөт замыг хайн нааштай алхмуудыг хийсээр байна.

Дэлхийн хүүхдийн байдал 2005 оны илтгэл нь хүүхэд бүрэн дүүрэн бололцоогоо ашиглаж сурч хөгжихэд ядуурал, зөрчилдөөн, ХДХВ/ ДОХ ямар аюул занал учруулж байгаад гол анхаарлаа хандуулж байна.

Хүүхэд гэдэг жинхэнэ утгаараа тэдний сурч мэдэх, тоглох, зэрэг бүхий л зүйлд нь гэр бүлээрээ оролцон дэмжин туслаж урамшуулж байдаг, томчуудын хязгааргүй хайр энэрлээр хүрээлэгдсэн хүн бүрийн амьдралын онцгой үе байдаг. 1989 онд Хүүхдийн эрхийн конвенци хүүхдийн эрхэд тулгуурласан хүүхэд насны шинэ тодорхойлолтыг зааж өгсөн байдаг. Уг конвенцид хүүхдэд зайлшгүй хэрэгтэй хүнс тэжээл, үйлчилгээгээр ханган тэдний оршин тогтнох, эсэн мэнд бойжих, боловсрох эрхийг хангахад олсон амжилтыг тэмдэглээд зогсоогүй хүүхдийг боолчлол, доромжлол, хүчирхийллээс хамгаалсан орчин бүрдүүлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн.

НҮБ-ын нарийн бичгийн дарга Кофи Аннан хэлэхдээ * Өнөөдөр дэлхий ертөнцөд амьдарч байгаа хоёр тэр бум хүүхдийн тэн хагас нь бидний эрмэлзэж буй хүүхдэд ээлтэй орчноос тэс ондоо, бүр илэрхий хүнд нөхцөлд амьдарч байна. Ядуурал тэдний эрхэм байдлыг үгүй хийж, амьдрал ахуйд нь заналхийлж, аятай бүх чадавхийг хязгаарлаж байна. Зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл тэдний гэр бүлийн амгалан тайван амьдралыг бусниулж итгэл найдварыг нь хөсөрдүүлж байна.

Олон хүүхэд хүчирхийллийн аюулд өртсөнөөр бид бүхний ирээдүйд ч аюул учирч байна. Зөвхөн бүх хүүхдийн эрхийг хангах зорилгодоо хүрснээр тус орнууд хөгжлийн болон энхийн зорилгоо хангаж чадах юм. 2005 онд улс орнууд Мянганы тунхаглалын биелэлтийн таван жилийн тайланг хэлэлцэхээр хуран цуглахдаа үүнийг оюун санаандаа тунгааж, бидний хүсэл эрмэлзлэлийг бодитой болгохуйц алсыг харсан шийдвэрүүд гаргана гэдэгт би итгэл төгс байна.* гэжээ.

Монгол улс Орос Хятад хоёр улсын дунд орших асар уудам нутагтай далайд гарцгүй орон. Тал хээр, ой тайга, хязгааргүй уудам говь цөл бүхий 1.566.000 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Энэ нь Өрнөд Европын нутаг дэвсгэрийг бүхэлд нь нийлүүлсэнтэй тэнцэх хэмжээ юм..Хүн амын нягтшил хамгийн багатай орны тоонд ордог. Эрс тэрс цаг уурын нөхцөлтэй өвөлдөө - 40с



хүртэл хүйтэрч,зундаа + 40с хүртэл халдаг. Засаг захиргааны бүтэн 31 аймаг, Улаанбаатар нийслэлээс бүрддэг. Нийслэл, аймаг нь дүүрэг, сум хороо багаас бүрддэг. Өнөөгийн байдлаар хүн амын 41.4 хувь нь хөдөө орон нутагт, 51 хувь нь нийслэлд амьдарч байна. 2000 оны хүн амын тооллогоор 2 сая 400 мянга, 500 орчим хүн ам тай, үүнээс 1 сая 112 мянга 500 орчим буюу нийт хүн 48,8 хувийг 19 - өөс доош насны хүүхдүүд эзэлдэг ба үүний 49.7 хувь нь хөвгүүд, 50.3 хувь нь охидууд байна.

Нийгэм эдийн засгийн байдлын хувьд 1990 он хүртэл Монгол улсын шилжилтийн өргөн үйл явц хамарч, өнгөрсөн арван жилийг улс төр эдийн засгийн асар хурдацтай шинэчлэлийн үе хэмээн тодорхойлдог. Эдийн засгийн либералчлалын дүнд олон нааштай алхмууд хийгдсэн боловч шилжилтийн үеийн явц шулуун дардан байгаагүйгээс амьжиргааны түвшин буурч, ажилгүйдэл, мөнгөний ханш уналт зэрэг олон сөрөг үр дагавар учирахын зэрэгцээ гудамжны хүүхдүүд, орон гэргүйчүүд, хог түүгчид гэх мэт нийгмийн эмзэг бүлгүүд гарч ирсэн юм. 1998 онд ДНБ 4.0 хувь байснаа 2000 онд 1.1. буурч , 2003 онд 5.5. хувь , 2004 онд 10 хувь болтлоо өсөж байгаа ч манай нийгэм эдийн засгийн амьдралд ядуурал, гэмт хэрэг буурахгүй хэвээр байна.


Социалист систем задарч, ЗХУ тэргүүтэй хуучин социалист орноос ирдэг байсан тусламж тэтгэлэг, зээл, огцом зогсож, улмаар Засгийн газар, боловсрол эрүүл мэнд, болон нийгмийн үйлчилгээний бусад салбарт хүндрэл учирч, ялангуяа алслагдмал бус нутагт эдгээр салбар бараг устаж үгүй болсонтой адил болжээ. Шилжилтийн эхний шатанд Засгийн газар зарим үйлдвэрийг хааж, нөгөө хэсгийг хувьчилж, нийгмийн үйлчилгээний санхүүжилтийг эрс танасан юм. Энэ нь манай ард түмэнд хүнд цохилт болж, амь зуух эх сурвалжгүй болсон олон ажилгүйчүүд мал дээр гарч, хувьдаа мал авах боломж нээгдсэний сацуу бэлчээр тархлагдах, ой мод сүйдэх, зэрэг экологийн гамшиг давхар тохиолдсон байна. Сүүлийн хэдэн жил ган зүд нүүрлэж, мал сүрэг үхэж үрэгдсэнээр хот хөдөөд ядуурал улам газар авлаа. Хахир хатуу өвөл, хөдөө орон нутаг дахь таагүй байдлын улмаас хүмүүс олноороо төв суурин газар бараадах их нүүдэлд хөтлөгдсөн юм. Ажилгүйдэл , амьжиргааны түвшин доогуур байгаа байдал болон нийгмийн халамж үйлчилгээ дутмаг зэрэг нь үүнд түлхэц болж байна. Монголын хүн амын 35 хувь нь албан ёсоор баталсан амьжиргааны баталгаажих түвшинд хүрэхгүй нөхцөлд амьдарч, нийт хүн амын 23 хувь нь нэн ядуу аж төрж байгаа дүр зураг харагдаж байна.

Эдийн засгийн уналттай зэрэгцэн хүүхдүүдийн өмнө нийгмийн шинжтэй бусад олон асуудал тулгарсан. Тэдний эцэг эхэд тулгарсан сөрөг үр дагавар нь ядуу зүдүүгийн эрхээр, мөн Төр засгийн дэмжлэг буурсны улмаас эцэг эхчүүдийн хувьд үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхэд нь улам хэцүү бэрх болсноор хүүхдүүд хүнд туссаар байна. Архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр оронгүй тэнэмэл байдал болон гэр бүл салалтаас үүдэлтэй хэрэг явдал нэмэгдсээр байгаа нь баримтаар хангалттай нотлогдсоор байна. Амьдралаа авч явах нэг хэсэг эцэг эхчүүдийн ихэнх нь хоногийн ихэнх хугацаанд гэртээ байхгүй тул хүүхдүүддээ хараа хяналт тавьж, сургаж хүмүүжүүлэхэд бэрхшээлтэй байдаг байна. Зарим хүүхэд гэр бүл болон сургууль хамт олны зүгээс учрах дарамт шахалтаас болж гэрээсээ дайжиж байхад нөгөө хэсэг нь хаягдаж орхигдсоноос хүүхдийн халамжийн төвүүд болон гудамжаар хэсүүжилч амь зогоодог байна.



Хүүхэд залуусын үйлдсэн гэмт хэргийн тоо буурахгүй байгаагаар цацуу залуучууд нь садар самуунд уруу татах, хулгай, дээрэм тонуул, айлган сүрдүүлэх зэрэгтэй холбоотой жижиг болоод зохион байгуулалтай гэмт бүлгүүдэд татагдан орох нь ихэсч байна. Хүүхдийг хамгаалах ёстой гэр бүл болон нийгмийн баталгаатай орчин байхгүй, хүүхдийн хүмүүжилд анхаарал тавих сургуулийн бодлого, багш нарын ур чадвар, чөлөөт цагаа өнгөрөөх газар гэх зэрэг сөрөг нөлөөнд автахгаас сэргийлэх хүчин зүйлс дутмаг байдгаас хүүхэд хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт холбогдох магадлал өндөр байсаар байна.

Энэ илтгэлийн 1-р бүлэгт судалгааны зорилго, арга зүй, хамрах хүрээ, 2-р бүлэгт хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудалтай тэмцэх хууль эрх зүйн орчин, олон улсын гэрээ акт, үндэсний бодлого хөтөлбөрүүд, 3-р бүлэгт хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай ойлголт, Монгол улсад судлагдсан байдал, хүүхдийн эсрэг гарч байгаа хүчирхийллийн хэлбэрүүд, 4-р бүлэгт дүгнэлт, саналын хэсгүүдийг тус тус багтаасан болно. Энэ судалгааны хүрээнд хүүхдийн бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн асуудлаар тусдаа томоохон судалгаанууд хийгдэж байгаа учир энэ тайланд оруулаагүй юм.



УН.МН
СУДАЛГААНЫ САН



**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ :
Судалгааны зорилго, арга зүй**

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл бол хүүхдийн эрхийг зөрчиж буй хамгийн ноцтой бөгөөд хор уршиг бүхий үйлдэл юм.

Хүүхдийн хүчирхийллийн талаар төрийн болон төрийн бус байгууллагын шугамаар тодорхой хүрээнд хэсэгчилсэн судалгаа хийгдсэн боловч зорилго нь өөр өөр, тэр бүр хүүхдийн асуудлыг хөндөхгүй орхих, үндэсний хэмжээний үр дүн гарахуйц тоо баримт цугларч, дүн шинжилгээ хийх боломжгүй байдал гардаг.

1.1. Судалгааны зорилго:

ХЭҮК нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл ямар хэлбэрээр илрэн гарч байгаа, тэр нь хаана, ямар салбар хүрээнд нийтлэг байгаа зэргийг судлан түүнийг илрүүлэх, зогсоох, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалах, сэргээх арга замыг тодорхойлж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх дүгнэлт, зөвлөмжийн төслийн боловсруулах ажлыг гүйцэтгэхэд оршино.

1.1.2. Судалгааны зорилтууд :

- Хүүхдийн хүчирхийллийн илрэлүүдийг олж тодорхойлох;
- Хүүхдийн хүчирхийлэл хаана, ямар бүлэг давхраанд нийтлэг гарч байгаа болон тэдгээрийн гарч байгаа шалтгаан нөхцлийн талаар дүн шинжилгээ хийх;
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалах, арга механизмыг тодорхойлж, дүгнэлт зөвлөмжийн төсөл боловсруулах;

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төлөв байдал судалгааг Хүний Эрхийн Үндэсний Комиссын захиалгаар 2004 оны 11-р сараас 2005 оны 3 сар хүртэлх хугацаанд хийгдлээ.

1.2. Судалгааны арга, хэлбэрүүд, хамрах хүрээ

- Баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлын эрхзүйн орчин, Энэ хүрээнд олон улсын гэрээ, МУ - ын үндсэн хууль, бусад хуулиуд, мөн үндэсний бодлого хөтөлбөрт тусгагдсан байдал, манай улсад уг асуудал судлагдсан байдал, судалгааны баримт, жишээнүүдийг хамарсан мэдээллийн сан байгуулах угтвар нөхцлийг бүрдүүлэх, задлан шинжлэх үнэлгээ өгөх явдал байв. Энэ явцад дараах баримт бичгүүдийг судлан шинжилж үнэлгээ хийв. Үүнд :



1. Монгол улсын хуулиуд, эрхзүйн баримт бичгүүд, бодлого хөтөлбөрүүд
2. Хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний талаар хийсэн судалгааны тайлангууд
3. Хүүхдийн асуудлаар зохин байгуулсан семинар сургалт, бага хурлын баримт бичгүүд
4. Судлаачдын бэлтгэсэн шинжлэх ухаан аргазүйн илтгэл, тааилцуулгууд
5. Хүүхдийн асуудлаар бичсэн ном товхимол гарын авлагууд

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудалтай хамаарах статистикийн үнэн зөв мэдээлэл олж авахад тодорхой бэрхшээлтэй тулгарч байлаа. Үндэсний статистикийн газар, бусад зарим байгууллагуудаас гаргаж авсан тоо баримт, мэдээлэлд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар холбогдох материалууд бүрэн тусгагдаагүй байв. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн байдал энэхүү судалгаанд гол төлөв Засгийн газрын мэдээлэл, бусад байгууллагуудын судалгаа шинжилгээний ажил, тус судалгаануудын хүрээнд хийсэн анкетууд, фокус бүлгийн болон сурвалжлагын судалгааны дүнг ашигласан болно. Эдгээр судалгааны дүн нь тэр бүр хоорондоо тохирохгүй, тэгээд ч нилээд ялгаатай хандлагууд илэрч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

- Сурвалжлагын судалгаа

Хүүхдэд нийгэм - эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн эцэг эхчүүд гэх мэт уг асуудалтай "холбогдох" 70 орчим тооны насанд хүрэгчдээс сурвалжлагын аргаар судалгаа явууллаа. Үүнд 14 төрийн албан хаагч, 8 төрийн бус байгууллагын ажилтан, 5 сургуулийн нийгмийн ажилтан, 12 өсвөр насны хүүхдүүд оролцлоо.

Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан \Хавсралт 1-ийг үзнэ үү \ ялгаатай асуултуудыг тавьсан юм. Төрийн албан хаагчдаас авсан сурвалжлага судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрхзүйн орчин, нийгмийн халамж үйлчилгээний тогтолцоо, мэдээллийн сүлжээ, хамтын хамтын ажиллагааны талаар ярилцсан бол төрийн бус байгууллагын ажилтан нартай хүүхэдтэй ажиллаж буй арга барил, хараа хяналтгүй болон хүчирхийлэлд өртөж буй хүүхдийн талаар, багш нартай ярилцахдаа өнөөгийн боловсролын тогтолцоо, нийгмийн ажилтны үүрэг роль, байр суурь ямар байгаа, хүүхдэд амьдрах ухаанын хүмүүжлийн ажил хэр зэрэг явагддаг, сурагчдын чөлөөт цагийн талаар тогтож ярилцсан юм. Эцэг эхчүүдээс мэдээлэл авах боломж, хүүхдийн бичиг баримтжуулалт, амьдралын нөхцөл, гэр бүлийн харилцааны асуудлаар голчлон ярилцсан юм. Уг сурвалжлагын судалгааг ХЭҮТ ийн хүүхэд хамгааллын нэгжийн ажилтан, хуульчдаас бүрдсэн багийн гишүүд, хүн нэг бүртэй ганцаарчлан ярилцах замаар зохион байгуулав.


- Фокус бүлгийн ярилцлага

Сурвалжлагын судалгаагаар орхигдож болзошгүй, зарим судалгааны тоо баримт, дүгнэлтүүдийг бататгах зорилгоор фокус бүлгийн нэг удаагийн ярилцлагад 6 өсвөр насны хүүхдүүдийг 12 - 15 насны охид хөвгүүдийг оролцуулан урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу ярилцлагыг зохион байгуулагч хөтөлж, ярилцлагын явцыг хянах, тэмдэглэх үүрэгтэй ажиглагч нар оролцсон юм. Энэ ярилцлаганд гэр бүл, сургууль хамт олны орчины харилцаа, чөлөөт цагийн талаар ярилцсан юм.



1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ

Энэ илтгэл ийг бэлтгэхэд одоо хэрэгжиж буй хуульчилгомжууд болон албан ёсны статистик баримт мэдээллийг тоймлон үндэслэсэн болно. Энэ илтгэл нь Улаанбаатар хотод ихэвчлэн чиглэгдсэн учир нь хүүхдийн чиглэлээр ажилладаг байгууллагын ихэнх нь нийслэлд төвлөрдөг байна. Хүүхдийн болон хүүхдийн эрх хамгаалахад оролцдог цагдаа, мөрдөн байцаах байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Хүүхдийн эрхийн төв, Хүчирхийлийн эсрэг үндэсний төв болон бусад халамжийн болон сургалт хүмүүжлийн төвүүдэд сүүлийн жил ирсэн өргөдөл гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийв. Мөн тэргүүн шугаманд ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд болон цагдаагийн газрын хүүхдийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал эрхэлсэн байцаагчидтай ч бас уулзаж ярилцсан нь бий.





ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлын эрхзүйн орчин

2.1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын эрхзүйн механизмууд

Хүүхэд гэж хэн бэ ?

0 - 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1-р зүйлд " Хэрэв тухайн хүүхдэд үйлчлэх хуулийн дагуу түүнээс дээш эрт насанд хүрсэн гэж үзэхгүй бол энэхүү Конвенцийн зорилгын үүднээс 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ" хэмээн тодорхойлсон байдаг.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд " Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ " гэж тодорхойлсон байна. Гэхдээ хууль тогтоомж нь нийгмийн ямар харилцааг зохицуулж байгаагаас шалтгаалан насанд хүрээгүй хүмүүс нь тухайн харилцааны субъект болохдоо түүний нас ялгаатай тогтоогддог. Тухайлбал; Монгол улсын Эрүүгийн хуулинд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг 16 насаар тогтоосон бөгөөд Эрүүгийн хуулинд заасан 8 төрлийн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх насыг 14 гэж хуульчилсан байна. Тухайлбал: Арван дөрвөөс арван зургаан хүртэлх насны этгээд зарим хүнд , онц хүнд гэмт хэрэг, түүний дотор " хүчиндэх " гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Олон улсын баримт бичгүүд хүүхдүүдэд олгогддог тусгай хамгааллыг тухайн хүнд үйлчлэх эсэхийг тогтоохын тулд мөн 18 насны хязгаарыг ашигладаг.

Хүүхдийн эрхээ эдлэх байдал болон тэдний эрхэд хязгаарлалт нь хүүхдийн наснаас хамааран харилцан адилгүй байх ёстой гэдгийг конвенци хүлээн зөвшөөрдөг. Мөн гэр бүл, төрийн оролцоог чухалчилсан байдаг. 5-р зүйлд заасанчлан:

" Оролцогч улсууд эцэг эхчүүдийн болон зохих тохиолдолд нутгийн ёс заншлын дагуу өргөтгөсөн гэр бүлийн буюу отог омгийн гишүүд, асран хамгаалагч болон хууль ёсоор хүүхдийн хариуцлага хүлээсэн бусад хүнээс энэхүү Конвенцид хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд хөгжиж буй авьяас чадварын дагуу хүүхдээ зохих ёсоор удирдан хөтлөх эрх үүрэг, хариуцлагыг нь хүндэтгэнэ."

Энэ зарчмыг Конвенцийн 12 -р зүйл дэх бас нэг заалт гүйцээдэг бөгөөд энэ нь :

" Оролцогч улсууд өөрийн гэсэн үзэл бодолтой байх чадвартай хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшилийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих анхаарлыг тавина."



Гэхдээ хүчирхийлэл, дарамтлал, мөлжлөгөөс хамгаалагдах хүүхдийн эрхийн тухай үндэстний наснаас хамааран ямар нэгэн байдлаар хязгаарлагдахгүй. Хүүхдийн өөрийгөө хамгаалах чадвар хязгаарлагдмал байдаг нь хүүхдийн нас чадварыг харгалзан үзсэнээр хамгаалуулах эрхийг нь илтгэхээс бус сулруулахыг илэрхийлэхгүй. Жишээлбэл: Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүүхдийг хамгаалах тухай НҮБ - ын дүрмийн 67-р зүйлд хүүхдийг ганцаарчлан хорих нь харгис хэрцгий, хүнлэг бус, муу үр дагавартай шийтгэл мөн гэж заахдаа хүүхдийг хамгаалуулах эрхийг зүй ёсоор тайлбарлах шаардлагатайг ойлгосон хэрэг юм. Харин насанд хүрэгчдийн хувьд тус зарчим заавал үйлчлэх албагүй.

Үндэстнүүдийг Лийг Хүүхдийн эрхийн анхны олон улсын тунхаглалыг баталсан 1924 онд хүүхдүүд эрх эдлэх ёстой гэдгийг олон улсын эрхзүйд зөвшөөрсөн байдаг. Дараа нь гарсан хүний эрхийн баримт бичгүүдэд, тэдгээрийн дотор 1948 онд батлагдсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал гэх мэт НҮБ - ын баримт бичгүүд мөн тус онд батлагдсан Хүний эрхийн Америкийн тунхаглал ба Хүний үүрэг хариуцлага гэх мэт бүс нутгийн шинж чанартай баримт бичгүүдэд хүний эрхийг хүчирхийлэл, дарамтлал, мөлжлөгөөс чөлөөт байх эрх хэмээн ерөнхий байдлаар тодорхойлж байсан. Эдгээр эрхүүдийг бүх хүүхдэд яваандаа 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын хэлэлцээр гэх мэт бусад баримт бичгүүдэд улам боловсронгуй болгосон.

Хүүхдийн онцлог, өвөрмөц эрхүүдийг тодорхой тусгасан эрхзүйн шинэ баримт бичиг болж байгаа талаар бүх нийтээр зөвшилцөөнд хүрсэн. 1989 онд НҮБ - ын Ерөнхий Ассамблей Хүүхдийн эрхийн тухай конвенцийг баталсан. Тус баримт бичиг маш богино хугацаанд дэлхийн 192 улсууд соёрхон баталж 2 орон одоогоор ороогүй байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үндсэн зарчим нь:

Хүүхэд бүр төрсөн цагаасаа эхлэн хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх ёстой. Энэ бол дэлхийн хүүхэд багачууд болон тэдний гэр бүлийн сайн сайхан амьдралыг баталгаажуулсан гол баримт бичиг болж чадсан юм. Тус конвенци нь 4 үндсэн зарчим дээр тулгуурладаг:

- Хүүхэд өөрийнхөө яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсааны болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, эрүүл мэндийн байдал, төрсөн нөхцөл, эцэг эх юм уу хууль ёсны асран хамгаалагчдын байдал болон өөр нөхцөл байдлын улмаас ялгаварлан гадуурхагдах ёсгүй.
- Хүүхэд эсэн мэнд бойжих, хөгжих эрхийг амьдралын бүх талбарт эдэлнэ. Үүнд: бие бялдрын сэтгэл санааны, нийгмийн сэтгэцийн, танин мэдэхүйн, нийгмийн болон соёлын зэрэг асуудлууд бүгд орно.
- Хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэхдээ нэн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг хамгаалах дээд зэргээр хангахад анхаарна.



- Хүүхэд өөртэй нь холбоотой асуудлыг шийдвэрлэхэд биечлэн оролцох, өөрийнхөө саналыг илэрхийлэх эрхтэй. Хүүхдийн санаа бодлыг хүндэтгэн анхааран сонсож, асуудал шийдвэрлэхдээ бүрэн ач холбогдол өгөх ёстой.

Хүүхдийн эрхийн конвенцид нэгдэн орсон оролцогч улсууд нь нэн тэргүүнд хүүхдийн эрхийг дээд зэргээр хангах үүргийг хүлээж, энэхүү баримт бичигт хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай бүх хууль тогтоомж, захиргааны болон бусад арга хэмжээг авна.

Хүүхдийн эрхийн конвенц 3 хэсэг 54 зүйлтэй.

Хүүхдийн эрхийн Конвенц нь хүүхдийн эрхийн олон улсын стандартуудыг хэд хэдэн арга замаар сайжруулсан. Хүүхдийг хүчирхийлээс хамгаалах нь эл Конвенцоор хязгаарлагдахгүй. Хүүхдийн эрхийг хамгаалах НҮБ болон олон улсын байгуулагаас гаргасан баримт бичгүүдэд тодорхойлсон байдаг.

Мөн Конвенцийн 43 " р зүйлийн дагуу Гишүүн улс бүр Конвенцийн хэрэгжилтийг хянах зорилго бүхий Хүүхэд хамгаалах олон улсын нэгэн чухал механизм нь Хүүхдийн эрхийг хамгаалах хороо юм. Тус хороо нь Конвенцийн гишүүн орнуудын сонгодог 18 гишүүнээс бүрддэг бөгөөд тэдгээр гишүүд тус тусдаа саналын эрхтэй.

Жилд 3 удаа хуралддаг тус хорооны үүрэг нь Конвенцийн гишүүн орнуудын тогтмол ирүүлэх ёстой тайлангуудыг хянах явдал юм. Тайлангуудад тухайн орон Конвенцид заасан эрхүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ямар хууль тогтоомжийг баталж, ямар арга хэмжээ авсан, ямар ахиц дэвшил гарсан, тус Конвенцитэй харших болон орхигдсон эсэхийг хянаж, дүнэлт зөвлөмжөө гаргадаг.

Хүүхдийн бүрэн бүтэн байх нөхцлийг хангахад язгуур эрх нь хангагдаагүй хүүхдэд олон талын саад тотгор нэгэн зэрэг учрах тохиолдлууд цөөнгүй байдаг. Дархлаажуулалт хийгдсэн ч байнга зодуулдаг хүүхэд эрүүл биш, сургуульд явдаг ч өөрийн үндэс угсаанаасаа болоод байнга доромжлуулж, гоочлуулж байдаг хүүхэд сурах таатай орчин байхгүй, биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдагдсан хүүхэд нийгмийн амьдралд оролцож хувь нэмрээ оруулах чадваргүй болдог.

Өнөө үед хүүхдийн хүчирхийллийн асуудлыг авч хамгааллын асуудал мөн адил хөндөгддөг. Боловсролын салбарыг авч үзэхэд сургуулиудад хүчирхийлэл байгаа нь сурагчдын тогтвортой суралцах түвшин доогуур байгаа далд шалтгаан байж болох юм. Эрүүл мэндийн салбарыг авч үзвэл эмнэлгийн байгууллагуудад эмчлэгддэг олон тооны шалтгаан нь тодорхойгүй гэмтэл, бэртэл болон зарим тохиолдолд удаан хугацаагаар тахир дутуу болгодог гэмтлүүдийн цаад шалтгаан нь хүчирхийлэл байж болох юм. Эдгээр уялдаа холбоог Хүүхдийн Эрхийн Комисс олонтаа илрүүлж байсан байна.

Хүчирхийлэл, дарамтлал, мөлжлөгөөс хамгаалагдах хүүхдийн эрхийг олон улсын хууль, бүс нутгийн байгууллагуудын эрхзүй стандартууд, бараг бүх орнуудын дотоодын хууль тогтоомжинд маш нарийн тодорхойлсон байдаг. Үүнээс үзэхэд хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц нь хүүхдүүд хамгаалагдсан дэлхий ертөнц гэдэг талаар хүн төрөлхтөн нэгдмэл зөвшилцөөнд хүрсэн юм.



1.1. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах Монгол улсын хууль тогтоомжид тусгасан байдал

Монгол улс Хүний эрхийн тухай түгээмэл тунхаглалд 1961 онд, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид 1981 онд, Хүүхдийн эрхийн Конвенцид 1990 онд, 1991 онд Сайн дурын үндсэн дээр гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай НҮБ - ын Конвенцид тус тус нэгдэн орсон. Мөн Үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ - ын Конвенци, түүний нэмэлт протоколуудыг судалж, тэдгээрт нэгдэн орох бэлтгэл ажлыг хийж байна.

Манай улс үндсэн хуулийнхаа үзэл баримтлал, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд хүний эрх, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, түүнийг зөрчигдөхөөс хамгаалах асуудлыг үндэсний хуульд тусган хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар хийж байна. Тухайлбал:

- Хүүхдийн эрхийг хамгаалах хууль 1996 онд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 1997 онд, Хараа хяналтгүй хүүхдийг албадан саатуулах тухай хууль 1997 онд, Гэр бүлийн тухай хууль 1999 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ - ын 182, 138 - р конвенцид нэгдсэн 2000, 2002 онд, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан-2003 онд, 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг тус тус батлан хэрэгжүүлж нийт 300 гаруй хууль үйлчилж байгаагийн 350 орчим заалт хүүхэд, хүүхдийн эрхийн тухай асуудлыг тусгасан байна:
- Монгол Улсын Үндсэн хуульд хүнийг нас хүйс, үндэс угсаа, нийгмийн гарлыг үл харгалзан улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахыг заасан нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалах язгуур эрхийг олгосон юм.
- Монгол улсын 2002 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртхууны эсрэг гэмт хэрэг" гэсэн бие даасан бүлэгт хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, эцэг эх, эхнэр, нөхөр төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх зэрэг нь хүүхдийн эсрэг шинжтэй хүчирхийлэл болохыг тодорхойлсон.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд "Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, айлган сүрдүүлэх, мөрдөн мөшгих, бусдаас тусгаарлах, зэрэг нийтлэг хэлбэрээр илэрч болохыг тодорхойлсон. Энэ хуулинд хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тус бүр тодорхойлсон байна.



- Гэр бүлийн тухай хуульд гэрлэгчдийн хэн нэгний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч, эсвэл учирсан нь тогтоогдсон бол эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцлахаар зааснаар хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх аргын нэг болсон.

Монгол улсын иргэний хууль, Эрүүгийн хууль болон Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хөдөлмөрийн тухай, Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай зэрэг хуульд хүүхдийн эсрэг гардаг орчныг тодорхой заасан. Тухайлбал:

- Гэр бүлийн тухай хуульд эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд сэтгэхүй, ёс суртхууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхэддээ хэрцгий хандах, эцэг эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглосон,
- Эрүүгийн хуульд төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол албадан ажил хийлгэх, баривчлах, үүний улмаас хүүхдийн амь нас хохирсон, хүнд хор уршиг учирсан бол хорих хүртэл ял шийтгэл оногдуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэг бүхий этгээд үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас хүүхдэд хор уршиг учирвал торгох, баривчлах, түүнчлэн хорих ялаар шийтгэх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол мөн адил торгох, эсхүл хорих ял оногдуулах зүйл, заалтыг тусган хэрэгжүүлсэн байна.
- Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийг ахуй нөхцлийн хувьд сайжруулсан байранд байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлэх, тэднийг бусад шижигтэн, ялагчдаас тусгайлан хорих заалт бий.

Хүүхдийн бие махбодийн хувьд шийтгэдэг явдлыг хориглох талаар гэр бүлийн орчин орно:

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтанд байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг торгох болон баривчлах шийтгэл ноогдуулахаар заасан;
- Эрүүгийн хуульд бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан буюу хараа, сонголтгүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж, дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүр мөсөн алдагдуулсан бол хорих ял шийтгэхээр заасан;
- Арван найман нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулахгүй гэж Монгол Улсын Эрүүгийн Хуульд заасан. Монгол улсын эрүүгийн бодлогод уг ялыг оногдуулах хэргийн төрлийг цөөрүүлэх, ялын төрлөөс бүр хасах чиглэлийг баримталж байна;



Иргэний харьяалалгүй болон орогнол хүсэгч хүүхдийн эсрэг бүр төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан заалтын талаар.

- Энэ талаар тусгайлсан заалт байхгүй боловч Монгол улсын Үндсэн хуульд тус улсад хууль ёсоор амьдран суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна гэж заасны дагуу тэдний эрх хамгаалагдах бүрэн боломжтой юм. Тухайлбал: Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд Монгол улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарахаар заасны дагуу хүүхдийн эрх хамгаалагдана.

Хүүхдийн хүчирхийллийн тухай тодорхойлолт, үйлчилдэг хууль тогтоомж нь хохирогч болон гэмт этгээдийн нас хүйс, тэдгээрийн хоорондын харилцаа холбооноос \хүүхдээ алах, гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл, доромжлол, цусан төрлийн хүчирхийлэл болон зодож шийтгэх\шалтгаалж ялгаатай байдаг эсэх талаар:

- Эрүүгийн хуулинд гэмт хэргийн шинжтэй хүчирхийлэл үйлдэгч болон түүний хохирогчийн насны байдал, тэдгээрийн хоорондын холбоог харгалзан тогтоосноор хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг ялгавартай тогтоож өгдөг.
- Мөн хуулиар насанд хүрээгүй хүүхдийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан, гэмт хэрэг үйлдэгчид нь уг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хэргийг хүндрүүлэх нөхцөл байдал болгох торгох, баривчлах ял зэргийг сонгон оногдуулах, харин арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол гэмт хэргийн онц хүндрүүлэх нөхцөл болгон хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэлээр заасан байна.
- Улсын Дээд Шүүх хохирогчийг байнгын шинжтэй, хэвшмэл, маягтай гурав ба түүнээс дээш олон удаа зодсон үйлдлийг "Байнга зодох", хоол унд өгөхгүй өлсөж цангаах, хүйтэн байранд түгжих, хүлэх, чимхэх хазах зэрэг хүний бие эрхтэн, сэтгэл санааны хувьд зовоосон үйлдлийг "Тарчлаах шинжтэй бусад хамааруулахаар тайлбарласан.\энэ тайлбар хуулийн нэгэн адил хүчин чадалтай эрхзүйн акт юм\эдгээрийг шүүхээс ял оногдуулахдаа хүндрүүлэх нөхцөл болгон авч үздэг.

Бэлгийн харьцааны доод хязгаар, хүйсийн ялгааг заасан байдал :

- Эрүүгийн хуулинд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн бол гэмт хэрэгт тооцдог. Эрэгтэй эмэгтэйг ялган тогтоосон болон ижил хүйстний талаар хууль тогтоомжинд тусгайлсан заалт байхгүй байна.



Гэрлэх насны доод хязгаар:

- Монгол улсын Үндсэн хууль, Гэр бүлийн хууийн дагуу 18 насанд хүрсэн Монгол улсын иргэн эрэгтэй, эмэгтэй сайн дурын үндсэн дээр гэрлэж болно.

Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг:

- Садар самууны тухай хуулинд садар самууныг сурталчлах, ном зохиол, кино, дүрс бичлэг,бусад зүйлсийг биелэн тараах, борлуулахыг хориглосон ерөнхий заалт бий. Эдгээр үйлдэлд хүүхдийг татан 18 оролцуулахыг\худалдах, худалдуулах\ хориглосон.
- 16 нас хүрээгүй хүнийг татан оролцуулсан,хүч хэрэглэн үйлдүүлсэн бол уг гэмт хэргийг хүндрүүлэн авч үзнэ.
- Эротик хэвлэлийг тусгай цэг буюу зөвшөөрдөгдсөн цэгт худалдах журамтай.
- Хүүхдийн порнографийг хязгаарласан,хориглосон нарийвчилсан зохицуулалт хараахан байхгүй.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой аливаа үйлдлийн талаар зохих хүмүүст мэдээлэхтэй холбоотой хуулийн заалт:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн,албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага,боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүрэг хүлээдэг. Мөн хуулиар шууд үүрэг хүлээдэггүй боловч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь мэдээлэх эрхтэй юм. Харин цагдаагийн байгууллага энэ талаар аливаа мэдээллийг хүлээн авч, шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй юм.

Гомдол гаргах талаар:

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг эх, асран хамгаалагч,харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар гомдол нэхэмжлэл гаргаж болно.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогч өөрөө гомдлоо гаргахаас гадна нийгмийн ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах, судалгаа үнэлгээ хийж, цагдаагийн байгууллагад мэдээлж, цагдаа хариу арга хэмжээг хэрхэн авах талаар тодорхой тусгасан.



- Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд хохирогч хүүхэд өмгөөлөгч авах, холбогдох байгууллага албан тушаалтанд хүсэлт тавих, баримт материал шалгуулах зэрэг эрхийг хангасан бөгөөд насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх бүх шатны ажиллагаанд тэдгээрийн эцэг эх, хууль ёсны төлөөлөгчөөс гадна өмгөөлөгчийг заавал оруулахаар тусгасан. \хурлыг хаалттай явуулах журмыг баримталдаг\

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шалгах талаарх тусгай журам :

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар шүүх нь хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтан, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, бусад нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шийдвэрийг шаардлагатай бол 24 цагийн дотор гаргана.
- Хувь хүний нууцтай холбоотой тухайлбал, гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцдэг.

Хүүхдийн эсрэг асуудлыг шийдвэрлэдэг шүүхийн бүтцийн талаар:

Монгол улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд зааснаар Монгол улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум ба сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг.

Гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний дагнасан шүүх байхгүй ,

1.2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар үндэсний бодлого хөтөлбөрт тусгасан байдал

Монгол Улсын Төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого болон Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогод хүүхдийг хүчирхийлэх, хэрцгийлэх, гэмт хэрэг, садар самууны зорилгоор ашиглах зэрэг болзошгүй аюулаас хамгаалах зорилт дэвшүүлсэн байна.

Хүний эрхийг хангах хөтөлбөр, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон орон нутгийн дэд хөтөлбөрүүдэд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах асуудал туссан бөгөөд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг өргөжүүлэх зорилт дэвшүүлсэн байна.

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах хөтөлбөрт " Хүүхдэд ээлтэй эрхзүйн шинэтгэл" гэсэн тусгай бүлэг оруулж, хүүхдийг хүчирхийлэл мөлжлөгийн аливаа үйлдэл, гэмт халдлагад өртөхөөс сэргийлж, гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдсон насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг олон улсын



жишигт хүргэнэ. Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл санааны бэлэн эрүүл мэндийн нөхөн сэргээх ажил, үйлчилгээг хөгжүүлж хэвшүүлднэ. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төлөв байдлын судалгаа хийж, энэ талаар мэдээллийн сүлжээг сайжруулна гэх мэт зорилтуудын дэвшүүлсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн төрөөс баримтлах бодлогод хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцлийг бүрдүүлэх нь нийгмийн эрүүл мэндийн нэг чухал асуудал болохыг тодорхойлоод хэрэгжүүлэх арга хэмжээний 4.2.6-д " Гэр бүл, хамт олон нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжиж, бухимдал, хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх замаар хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаална" гэж заасан байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад нийгмийн эрүүл мэндийн 18 хөтөлбөрүүд хэрэгжиж байгаагаас хөтөлбөрүүд нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зарим асуудлыг хамарсан байна. Тухайлбал: " Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүний нөхөн үржихүйн эрхийг дээдлэх, хүйсийн тэгш байдлыг хүндэтгэх асуудлаар шаардлагатай эрхзүйн зохицуулалт хийх",\3.1.5.\

"Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр"-т хүчирхийллээс шалтгаалсан осол гэмтлийн хэлбэрүүд, түүний шалтгаан тархалтыг холбогдох байгууллагатай хамтран судалж, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

"Сэтгэцийн эрүүл мэнд хөтөлбөр"-т иргэд олон нийтийн оролцоог " Гэр бүл хамт олны дотор харилцан бие биеэ хүндэтгэсэн, ойлголцсон, хүчирхийлэл, сэтгэлийн дарамтаас ангид орчин бий болгох"-оор тус тус тодорхойлон заасан байна.

Нэмэлт мэдээллийг Хавсралт 2- ыг үзнэ үү.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ГУРАВДУГААР БҮЛЭГ :

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл Монгол улсад судлагдсан байдал түүний илрэх хэлбэрүүд, нийгэм -эрхзүйн орчин

3.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт

Хүчирхийлэл гэдэг нь аливаа нэгэн субъект өмнөө тулгарсан зорилгод хүрэхийн тулд албадлагын арга хэрэглэхийн авч үздэг. Хүчирхийлэл нь хүний амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, аюулгүй орчинд амьдрах, эд хөрөнгөтэй байх гэх мэт хүний салшгүй эрхүүдийг хөнддөг.

Хүчирхийлэл нь Хүний Эрхийн Хорооноос хүлээн зөвшөөрснөөр бусдыг зовоон тарчилгах, харгис хэрцгий хандах үйлдлийг агуулж байдаг. Үүнд :

1. Хүчтэй өвдөлт шаналлыг үүсгэдэг
2. Төлөвлөгдсөн үйлдлээр явагддаг
3. Зорилго агуулдаг
4. Тодорхой оролцоотойгоор үйлдэл болон эс үйлдлээр илэрдэг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь

Хэн нэг / насанд хүрэгчид болон үе тэнгийнхэн/-ий зүгээс биеийн хүч, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь хүүхдийн төрөлхийн болон хуулиар тогтоосон эрхээ эдлэх хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг бие хүн болон төлөвших, хөгжихөд саад болсон сэтгэл зүйгээр, биеийн хүчээр, бэлгийн харилцаагаар, үг хэлээр, үл хайхарч шоовдорлох замаар сэтгэл санаа, бие махбодод гэмтэл учруулж болохуйц, эсвэл учруулсан аливаа үйлдэл юм.¹ Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт нь дараах үндсэн 5 хэлбэрээр илэрдэг². Үүнд:

1. **Шоовдорлох:**

Эцэг эх асран хамгаалагчийн зүгээс хүүхдийнхээ оюун санаа, бие бялдрын хөгжил, түүний эрүүл мэндийг хамгаалах зэрэгт авах ёстой арга хэмжээнүүдийг авахгүй, хайхрахгүй байгаагаар илэрхийлэгдэнэ.

2. **Асран хамгаалагчгүй орхих:**

Эцэг эх асран хамгаалагчид хүүхдээ гэр орон болон амьдрах орчиндоо асран хамгаалагчгүйгээр ганцааранг нь орхих, төөрүүлэх, хаях гэх мэт тохиолдлуудыг хэлнэ.

¹ Хүүхдийн эрхийг хамгаалах хүүлийн тодорхойлолтоос

² Соросын сангаас хэрэгжүүлсэн “Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөр”-ийн хүрээнд цагдаагийн ажилтнуудад зориулсан гарын авлагыг үндэслэв 2003 он



3. Бие махбодийн хүчирхийлэл:

Насанд хүрэгчид болон үе тэнгийхний зүгээс хүүхдийн бие махбодийг өвтгөх, түүнд гэмтэл учруулахыг хэлэх бөгөөд энэ тохиолдолд хүүхэд өөрийгөө хамгаалах чадвар мөхөс байдаг.

4. Сэтгэл санааны хүчирхийлэл:

Энэ төрлийн хүчирхийлэл нь хүүхдийн өөрийн үнэлэмж, түүний сэтгэлзүйн хөгжилд сөргөөр нөлөөлнө. Үүнд: Хэл амаар доромжлох, нэр хоч өгөх, элдэвлэх, гадуурхах, үл ойшоох, хүсэл эрмэлзлийг нь мохоох, айлган сүрдүүлэх, хуурч мэхлэх зэрэг үйлдлүүд багтана. Энэ нь нөгөө талаас хүүхдийн сэтгэл санааны өсөлт хөгжилтөнд зайлшгүй шаардагддаг, хайр халамж, энхрийлэл, харилцан итгэлцэл, урамшуулан зоригжуулах гэх мэт сэтгэлийн дэм үзүүлэхгүй байх зэрэг таагүй харилцаа хандлагыг илэрхийлдэг.

5. Бэлгийн хүчирхийлэл

Томчууд болон үе тэнгийнхний зүгээс эрх мэдэл, хүчгүй, хараат байдлыг ашиглан айлган сүрдүүлэх, хууран мэхлэх, албадан хүч түрэмгийлэх гэх мэт аргаар шууд болон шууд бус замаар бэлгийн ямар нэгэн төрлийн харилцаанд татан оролцуулах үйлдлүүдийг хэлнэ. Үүнд зөвхөн бэлгийн харьцаанд орсон тохиолдлыг бус завдах үйлдлүүд ч хамаарна.

3.2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл Монгол улсад судлагдсан байдал

Засгийн газраас эрхзүйн хүрээнд Хүүхэд эмэгтэйчүүдийн аж байдлын хийсэн үнэлгээ (НҮБХАС 2000), ОУХБ - ын 182 - р конвенци, Хүүхдийн эрхийн тухай НҮБ - ын Конвенцийн нэмэлт протоколуудад Монгол улс нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд хуулийн харьцуулсан судалгаа хийхэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл хамаарагдсан байна.³

Эдгээр үнэлгээ судалгааг үндэслэж, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах хөтөлбөрт " Хүүхдэд ээлтэй эрхзүйн шинэтгэл" гэсэн тусгай бүлэг оруулсан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний судлагдсан байдлыг авч үзэхэд хүчирхийлэлд өртсөн ба өртөж болзошгүй эсрдэлд байгаа хүүхэд болон тэдний гэр бүлийн судалгааг энэ чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллага, нэгжүүд түлхүү хийдэг байна. Үүнд Хүүхдийн төлөө Үндэсний Газар, Цагдаагийн Ерөнхий Газрын хүүхдийн тасаг, Хүүхдийн хаяг тогтоох шалган хуваарилах байр, Хүүхдийн сурган хүмүүжүүлэх тусгай төв, Нялхсын клиник сувилалд зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхдийн эрхийн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв зэрэг төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаануудыг нэгтгэн хүүхдийн эсрэг хүчирхийлэл хаана, хэний зүгээс, ямар хэлбэрээр илэрч, ямар хохирол учирсан, Төрийн зүгээс хохирогч хүүхдүүдийг хамгаалах ямар хариу арга хэмжээ

³ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар НҮБ - ЕНБД - ын асуулга, түүнд өгсөн хариулт, Монгол Улс 2004



авч байгааг агуулгаар ангилж, 1998 - 2004 онуудад хийгдсэн судалгаануудыг дор хураангуйлан дурдсан болно.

Монгол улсад хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар үндэсний хэмжээний статистик мэдээлэл хязгаарлагдмал байна. Үүнийг дараах шалтгаанаар тайлбарлаж болох юм⁴ :

- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал Үндэсний статистикийн хүрээнд багтаагүй,
- Хүүхдийн эсрэг нуугдмал зөрчлүүдийг өрхийн болон түүвэр судалгаагаар гаргаж ирэх боломж муутай
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, дарамт зэрэг хүүхдийн эрхийн зөрчиж буй асуудлууд гол төлөв далд нуугдмал байдалд үйлдэгддэг
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт дутмаг байдгаас эл асуудлыг мэдээлэх олон нийтийн хараа хяналт, оролцоо хангалтгүй
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд төр нийгмийн үйлчилгээ ямар хариу арга хэмжээ авсан хяналтын талаарх хяналт, мэдээллийн тогтолцоо байхгүй
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хувь нь гэр бүл, сургууль, дотуур байр зэрэг хүүхдийн амьдран байгаа орчны хүрээнд гардаг тул хүүхэд өөрийн болон гэр бүлийн нэр төр, багш, анги хамт олны зүгээс ирж болзошгүй хариу дарамтлал зэргээс болгоомжлон мэдээлдэггүй зэрэг шалтгаануудыг дурдаж болно.

3.3. Төрийн болон ТББ - уудын хэсэгчилсэн судалгаануудаас хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрэх хэлбэрүүдийг илэрхийлсэн үзүүлэлтүүд

Хүүхдэд нийгэм - эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын хүрээнд хийгдсэн судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд төлөөлж чадахгүй ч хүн амын тодорхой хэсгийн хамарсан, тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан баримтжуулсан тул огт үндэслэлгүй баримт гэж үгүйсгэх аргагүй юм. Иймд байгаа судалгааны материалууд дээр үндэслэн хүчирхийлэл гарч байгаа хэлбэрүүдийг тодорхойлохыг хичээв.

Монгол улсад анхаарал татахуйц түгээмэл шинжтэй нийгмийн сөрөг үзэгдэл болоод байгаа Гэр бүлийн хүчирхийлэл нь хамгийн аюулгүй байх анхдагч орчин нь хувь хүний баталгаагүй орчин болж байгааг "Монголын хүний хөгжлийн илтгэл 2003" тэмдэглэсэн байна.

1998 онд ХЭҮТ МУИС – ийн Хүн амзүй, сургалт судалгааны төвтэй хамтран 21 аймгийн нийгмийн бүх төлөөллөөс 5000 хүнийг хамруулж, үүнээс 1131 нь хүүхэд оролцсон байна. Эдгээр хүүхдийн 54.6 хувь нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг гэж хариулсан байна. Үүнээс хойш энэ үзүүлэлтийг батлах үндэсний хэмжээний судалгаа хийгдээгүй байна. Судалгаанд санамсаргүй

⁴ Хүүхэд хамгаалал ын байдал судалгаа UNICEF Монголмаа 2005



түүвэрлэлтээр сонгон хүчирхийллийн илрэх хэлбэрүүдийг нарийвчлан задалж асуулга, ганцаарчлан ярилцах аргуудыг хэрэглэсэн байна.⁵

2003 онд Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхий зөн- Монгол ОУБ –тай хамтран 21 аймгийн төв, хөдөөгийн нэг сум, УБ хотын 9 дүүрэгт оршин суух иргэдээс нийт 1430 буюу 5- 19 насны охид хамрагдаж, тэднээс 5 охид тутмын 1 нь хүчин, бэлгийн харилцааны хүчирхийлэлд ямар нэгэн байдлаар өртсөн байна" гэсэн дүгнэлт хийжээ.⁶

3.3.1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл хаана үйлдэгдэж байна вэ ?

"Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэр бүлд хамгийн их үйлдэгддэг " хэмээн судалгаанд хамрагдсан УБ хот, Баянхонгор аймаг, сумдаас төлөөлж оролцсон 500 хүүхдийн 73,3 хувь, 152 эцэг эхчүүдийн 86,6 хувь, хувь нь хүлээн зөвшөөрчээ.⁷ \Хавсралт 3 - үзнэ үү.\

...Аав намайг долоо хоногт 2-3 удаа зоддог. Эхлээд ээжийг зодно, дараа нь намайг... Аавдаа зодуулж, эмнэлэгт хэвтэж, төмсөгний хагалгаанд орсон. 10 настай хүүгийн ярианаас ,,,

,,, Гэмтлийн эмнэлэгт ирсэн 5 настай хүүг аав нь тамхины галаар хөлийн улнаас зулайг нь хүртэл түлсэн байсан. Гэмтлийн эмчийн ярианаас ...

Сургуулийн орчинд зарим багш нар сурагчиддаа зүй бусаар харьцаж, анги хамт олны дунд нэр хүндийг гутаах, ялгаварлах, зодох гэх мэт үйлдлүүд цөөнгүй тохиолддог гэж судалгаанд оролцсон 450 сурагчдын 60 хувь нь хариулжээ. 80 багш нарын 38 хувь нь хүлээн зөвшөөрчээ. Мөн сурагчдын 26,8 хувь нь үе тэнгийхний зүгээс хүчирхийлэлд өртдөг гэсэн байна. Энэ судалгаанаас үзэхэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь гэр бүлээс гадна сургуулийн орчинд түгээмэл байдгийг илэрхийлж байна.⁸

Шигтгээ

Манай ангийн багш ноднин дөнгөж сургууль төгсөж ирсэн залуухан эмэгтэй. Тэгсэн хирнээ хүүхдүүдээ баян ядуу, хувцас хунар сайтай муутай, өнгө үзэмжээр ялгаварладаг. Сурлага, сахилга бат, амьдралын бололцоо муутай хүүхдүүдийг ад үзэж, ямар нэгэн шалтгаанаар өөр сургууль руу шилжихийг шаарддаг. Жишээ нь намайг байнга ад үзэн тойргийн бус гэсэн шалтгаанаар өөр сургууль руу

⁵ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар НҮБ – ЕНБД- ын асуулга, түүнд өгсөн хариулт, Монгол Улс 2004

⁶ Хүйсийн тэгш эрхийн төв, дэлхийн зөн- Монгол ОУБ-ын Хүнд нөхцөл дэх хүүхэд хөтөлбөр

⁷ Хүүхдийн хүмүүжил, хүчирхийллийн талаарх ойлголт мэлэг хандлага ХЭҮТ АХИС 2001

⁸ "Хүүхдийн хүмүүжил, хүчирхийллийн таааарх ойлголт, мэдлэг, хандлага, ХЭҮТ, АХИС 2001 он"



шилжихийг шаардан, өчигдөр ангид орж ирээд цүнхийг минь булаан авч өгжор нь байсан бүх зүйлийг асгаад, сургуулиас тавьж өгсөн сурах бичгүүдийг хураан авч өөр хүүхдэд өгсөн.

Ноднин жил манай ангийг авангуутаа л иймэрхүү маягтай надтай харьцаж байсан. Би бодохдоо намайг сурлага муутай, бас анги засварын 4500 төгрөгийг аав ээжийн цалин буухгүй байсаар өгөх хугацаанаас нь 7 хоног хожигдуулсан тэр үеэс л эхлэн намайг ингэдэг болсон гэж боддог. Би энэ ангид 1-р ангиасаа 7-р анги хүртлээ явсан. Ангийнхаа найз нөхөд, дассан сургуулиасаа ганц энэ багшаас болж салмааргүй байна, би яах вэ?

15 настай. Охин

3.3.2. Хэн хүүхдийг хүчирхийлж дарамталдаг вэ?

Судалгаанаас үзэхэд өөрийгөө бусдын хүчирхийлэл дарамтанд өртдөг хэмээн үзсэн хүүхдүүдийн 93 хувь нь ямар нэгэн байдлаар таньдаг хүнийхээ, 7 хувь огт танихгүй хүний хүчирхийлэл дарамтанд өртдөг гэж хариулснаас ямар хүмүүс хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг болохыг тодруулжээ.

Төрсөн эцэг 18.3%, хойд эцэг 8.5%, төрсөн эх 9.9%, хойд эх 2.8%, төрсөн ах, эгч 14.1%, төрөл садан, эмээ өвөө 1.4%, 4.2% үе тэнгийнхэн 26.8%, огт танихгүй хүн 5.6%, автобусны кондуктор 1.4% гэж үзсэн байна.

Энэ баримтаас үзэхэд хүүхдийн хууль ёсны асран хамгаалах үүрэгтэй хамгийн ойр дотны хүмүүс болох гэр бүлийн гишүүд, мөн сурган хүмүүжүүлэх үүрэг бүхий багш нарын тодорхой хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг болох нь харагдаж байна. Насанд хүрэгчдээс гадна үе тэнгийн насны хүүхдүүд ч бие биеэ хүчирхийлэх явдал нилээд их байгааг уг судалгаа харуулжээ.⁹

Үе тэнгийнхний дарамт буюу хүүхэд хүүхдээ хүчирхийлэх:


Үе тэнгийнхэн буюу хүүхэд хүүхдээ хүчирхийлж дарамтлах явдал тэдний амьдрах, сурах гэр орны болоод сургуулийн ойролцоо гудамж талбай, анги танхимд түгээмэл үзэгдэл болж байна. Ахлах ангийн, нэг ангийн, хамт амьдардаг хүүхдүүд ч бие биенээ дээрэлхэх, дээрэмдэх, зодох, мөнгө нэхэх, үг хэлээр дарамтлах явдал газар авсан гэж судалгаанд оролцсон эцэг эхчүүд хүүхдүүдийн 26.8%, багш нарын 14.3% үзсэн байна.¹⁰

Дээрхи асуудал нь сүүлийн үед нилээд анхаарч үзэх асуудал болж байна. Учир нь хүүхэд хүүхдээ хүчирхийллийн бүхий л төрлөөр дарамталж, зарим нэг нь улмаар гэмт хэргийн шинжтэй болж ирлээ. Гэмт хэрэг үйлдээд хорих ял эдлэж байгаа хүүхдүүд гэмт хэрэг үйлдэхэд нөлөө үзүүлсэн эзнээр хамгийн их буюу 42% нь үе тэнгийнхнээ дурдсан байна.¹¹

⁹ Хүүхдийн хүмүүжил, хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага, ХЭҮТ, АХИС 2001 он

¹⁰ Хүүхдийн хүмүүжил, хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага ХЭҮТ, АХИС 2001 он

¹¹ Хүүхдийн гэмт хэрэг. Нөхцөл байдал, шалтгаан судалгаа ХЭҮТ, ЦеГ судалгаа 2002 он



3.3.3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ямар хэлбэрээр илэрч байна вэ ?

1131 нь хүүхэд оролцсон байна. Уг судалгаагаар дараах тоон мэдээ гарсан байна.

Үүнд:

- Монгол 2 хүүхэд тутмын нэг нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг. Үүнээс:
- 20.06% нь биеийн хүчний
- 56.8% нь сэтгэл санааны
- 2.09% нь бэлгийн харилцааны
- 21% нь үл тоомсорлох буюу шоовдорлох хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг.¹²

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүнд болон хүндэвтэр гэмтэл авагсдын тоо 2002 онд өмнөх оныхтой харьцуулахад 2.5 дахин өссөн тоон мэдээ байна.¹³

3.5. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар эцэг эх, багш нарын хандлага:

УИИ.МН
СУДАЛГААНЫ САН

¹² 1998 онд ХЭҮТ МУИС – ийн Хүн амзүй, сургалт судалгааны төвтэй хамтран 21 аймгийн нийгмийн бүх төлөөллөөс 5000 хүнийг хамруулж, үүнээс 1131 нь хүүхэд оролцсон байна. Эдгээр хүүхдийн 54.6 хувь нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг гэж хариулсан байна.

¹³ гэр бүл дэх хүчирхийлэл – Баримтат мэдээлэл ХЭҮТ 2002



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл хир их байдаг эсэх:

	Хүүхэд	Эцэг эхчүүд	Багш нар
- Хэвийн үзэгдэл –	34.2%	36.2%	27.9%
- Анхаарууштай асуудал –	49.3%	56.6%	65.1%
- Бараг байхгүй –	16.5%	7.2%	7.0%

1995 - 2004 онуудад ХЭҮТ -д 7100 хүн үйлчлүүлсний \ орон нутгийн 10 салбарыг оруулав\ амь нас эрүүл мэндэд нь аюул учирсны улмаас 1375 эмэгтэйчүүд 1405 хүүхдийн хамт ирж Хамгаалах байранд байрласан байна. Нийт үйлчлүүлэгсдийн 16 хувь нь гэр бүлийн гишүүдийн зүгээс хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд байна.

Өсвөр насны хүүхдүүдийн дунд авсан судалгаагаар хүүхдүүдийн хувьд үе тэнгийхний ирдэг дарамт, хүчирхийлэл хамгийн өндөр хувийг эзэлж байгаа нь хүүхдүүдийн дунд хүчирхийлэл өндөр байгааг харуулж байна.

3.3.4. Хүчирхийллээс хүүхдэд учирч буй хор хохирол

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдийг гэрээс дайжуулж, гудамжинд тэнүүчлэн амьдрахаас өөр аргагүй байдалд хүргэж байгаа нь 2002 онд НҮБ – ын Хүүхдийн Сангаас явуулсан " Монгол хүүхдийн насанд хүрээгүй иргэдийн гэмт хэргийн байдал" судалгаагаар хот суурин газарт 3700 хараа хяналтгүй хүүхэд байгаагийн 50 хувь нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд байсан гэсэн үзүүлэлт гарчээ.¹⁴



¹⁴ Монголын хүний хөгжлийн илтгэлээс



3.4. Хүүхдэд нийгэм эрхзүйн үйлчилгээ сурвалжилсан албан ёсны тоо баримтаас

3.4.1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг:

Энэ жилийн тоон үзүүлэлтээр хүүхдийн эсрэг гэмт хэрэг 1999 оныхтой харьцуулахад 10 орчим хувиар өссөн байна. Зөвхөн 2004 онд гэмт хэргийн улмаас 194 хүүхэд нас барж, 667 хүүхэд гэмтэж бэртсэн байна. Эдгээр бэртсэн хүүхдийн хэд нь бүр мөсөн эдгэрч, хэд нь байнгын тахир дутуу болж байгаа талаар мэдээлэл хомс байна. 2003 – 2004 онуудад гэмт хэргийн улмаас нас барсан нийт 390 хүүхдийн 55 хувь нь орон нутагт, гэмтэж бэртсэн 1374 хүүхдийн 52 хувь нь Улаанбаатарт харьяалагдаж байна.¹⁵

1999 онд нас барсан хүүхэд	178,
гэмтэж бэртсэн хүүхэд	704
2003 онд нас барсан хүүхэд	196,
гэмтэж бэртсэн хүүхэд	707
2004 онд нас барсан хүүхэд	194,
гэмтэж бэртсэн хүүхэд	667

Гэмтэл согог сэргээн засах эмнэлгийн дүн бүртгэлээс:

0-19 насны хүүхэд 2081 гэмтсэн, мөн 10 - 19 насны 40 хүүхэд санаатайгаар өөрийгөө гэмтээсэн, 0-19 насны 536 хүүхэд гадны нөлөөнөөс гэмтсэн гэсэн баримтыг тус эмнэлгийн дүн бүртгэлээс авлаа. Гэвч хэний зүгээс хаана бие махбодийн гэмтэл авсан тухай асуулганд ороогүй байдгаас эл мэдээллийг дээрх баримтаас үзэх боломжгүй байв. Хавсралт аас .. үзнэ үү.

ЭМЯ, ЭТУГ, НҮБХС -аас хамтран 2004 онд хийсэн "Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар" судалгаа нь гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар нь эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар дүгнэлт гаргаж "Хүүхдийн эсрэг хүчирхийлэл" хэсэгт судалгаанд оролцсон 7- 24 хүртэлх насны хүүхэд залуусын 38.7% нь ямар нэгэн хэлбэрээр дарамтлагдсан ба тэдний 28.9% нь зодуулсанаас бэртэж гэмтсэн, 18.8% нь хэл амаар доромжлуулж, 13.8% нь сэтгэл санааны дарамтанд орсон, 8.6% эзийн засгийн хавчигдалд орсон байсан гэжээ.

3.4.2. Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг

Шүүхийн статистик мэдээгээр 2000 онд 990, 2001 онд 1034, 2002 онд 1162 насанд хүрээгүй хүмүүс ял шийтгүүлсэн байна.¹⁶

¹⁵ Ц ОНХХ - ийн мэдээ 2004

¹⁶ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай итгэлийн ХЭҮК, 2003.



Эндээс үзэхэд хууль зөрчсөн насанд хүрээгүй хүүхдүүдийн тоо нэмэгдсээр иржээ. Харин ЦЕГ - ын мэдээгээр насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо 1999 онтой харьцуулахад бага хэмжээгээр буурсан байна. 1999 - 2000 - 2004 онуудад насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн тоо 2003 оныг эс тооцвол дорвитой буураагүй байна.

Хүснэгт¹⁷

Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо, оноор

	1999		2000		2001		2002		2003		2004	
	ГХ тоо	НХХ тоо	ГХ тоо	НХХ тоо	ГХ тоо	НХХ тоо	ГХ тоо	НХХ тоо	ГХ тоо	НХХ тоо	ГХ тоо	НХХ тоо
Орон нутагт	631	807	611	809	718	826	701	878	625	1023	611	927
Улаанбаатар	534	763	433	657	427	848	358	825	257	612	423	621
Бүгд	1165	1570	1044	1466	1145	1674	1059	1703	882	1635	1034	1548

Хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн дийлэнхийг бусдын эд зүйлсийг хулгайлах, дараа нь танхайн хэрэг эзэлж байна. 2001 оныхтой харьцуулахад 2004 он байдлаар хүүхдийн гэмт хэргийн дотор хүн амь, иргэний эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг өссөн байхад хулгай, танхайн хэргийн тоо бага зэрэг буурсан байна. Гэхдээ хулгайн хэрэгт орсон хүүхдийн тоо бараг буураагүй, булаалтын хэрэгт холбогдогч хүүхдүүдийн тоо буурсан ч хэргийн тоо буураагүй байна. Хүүхдийн үйлдсэн танхай хэргийн дийлэнх нь үе тэнгийн хүүхдүүд байдаг байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд үе тэнгийнхнээсээ ирдэг дарамтыг нийгмийн зүгээс ирж буй дарамтын дотроос хамгийн өндөр хувиар буюу 26.8 хувиар илэрхийлсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн 11 орчим хувийг хараа хяналтгүй хүүхдүүд эзэлдэг байна. Хараа хяналтгүй хүүхдийн тоо тогтвортойгоор буурсаар ирсэн ч Хаяг тогтоох газарт ирж буй хараа хяналтгүй хүүхдийн тоо нэмэгдсээр ирсэн байдлаас үзэхэд удаан хугацаагаар хараа хяналтгүй байсан хүүхдүүд илүүтэй гэмт хэрэг үйлддэгийг харуулж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан албан ёсны мэдээллээс сүүлийн жилүүдэд гарсан хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүүхэд оролцсон гэмт хэргийн улмаас бэртэж гэмтсэн хүүхдийн тоог авч үзвэл¹⁸:

¹⁷ ЦЕГ ОНХХ 2004



Зураг 3 Хараа хяналтгүй хүүхдүүдээс гэмт хэрэг үйлдсэн байдал

Гэмт хэргийн төрөл	2000	2001	2002	2003	2004
Хүчин	34	46	48	47	43
Иргэдийн эрх чөлөөний эсрэг	93	63	75	76	70
Булаалт, дээрэм	64	62	65	64	62
Дүн	191	171	188	187	175

Хараа хяналтгүй хүүхдүүдийн үйлдэж байгаа гэмт хэргүүдийн 70 - 80 хувийг хулгай, танхай, дээрмийн хэргүүд эзэлж байна. Нөгөө талаас хараа хяналтгүй хүүхдүүдийг насанд хүрэгчид дарамт шахалт үзүүлэх, гэмт хэрэгт уруу татаж байна. Орц, хонгил, дулааны цооногт амьдарч байгаа охидууд байнга хүчингийн гэмт хэргийн золиос болдог байна.

Зөвхөн шүүхээр хэлэлцэгдэж шийдвэрлэгдсэн хэргийн хэмжээнд эрүүгийн хэргийн зүйлчлэлээр гаргасан хүүхдийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн мэдээ.¹⁹


Гэмт хэргийн төрөл	2001	2002	2003
Хүүхдээ хаяж төөрүүлсний улмаас хохирсон хүүхэд	3	2	1
16 нас хүрээгүй хүний хурьцал үйлдсэний улмаас хохирсон хүүхэд	6	9	5
Дүн	9	11	6

¹⁸ Цег-ын мэдээлэл 2004.11.30

¹⁹ Улсын дээд шүүхийн судалгааны төвийн мэдээ
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар НҮБ-ын ЕНБД-ийн асуулга, түүнд өгсөн хариулт Монгол улс 2004 он



Зураг 7: Хараа хяналтгүй хүүхдүүдээс гэмт хэрэг үйлдсэн байдал



Эх сурвалж: ЦЕГ-ын Олон нийтийн харилцааны хэлтэс

3.4.3. Ганц худгийн урьдчилан хориход саатуулагдаж буй хүүхдүүд

ХЭҮК-оос 2001 онд хийсэн судалгаагаар Ганц худагт хоригдож буй 70 орчим хүүхдийн 60-аад хувь нь өмгөөлөгчгүйгээр шүүгдсэн гэсэн баримт байна. Энэ 2005 оны 3 сарын байдлаар 51 хүүхэд хоригдож байна. 3 охид, 48 хөвгүүд байна. Тэднээс өмгөөлөгч авсан 38, үлдсэн 13 хувь нь өмгөөлөгчтэй гэж бүртгэгдээгүй байна.²⁰

Цагдан хорих байрны нөхцлийг хангах талаар дараах арга хэмжээнүүдийг авчээ:

- Нэг өрөөнд 4 хүүхэд байрлуулахаар засварласан
- Урьдчилан хорих байранд хүмүүжлийн тасалгаа байгуулан, харилцаа, амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулдаг болсон байна
- Хүүхдүүдийн өгүүлж буйгаар тэдний ихэнх нь өөрийн эрх, үүрийг мэддэггүй буюу цагдаа баривчлах үед юу хийх талаар мэддэггүй, хэргийг прокурорт шилжүүлэх, шүүх хурал явагдахын өмнө л өмгөөлөгч авах эрхтэй тухайгаа мэдсэн байна.²¹

Насанд хүрээгүй хүүхдүүд болон тэдний эцэг эх байцаан шийтгэх үйл ажиллагааны аль болохоор эрт шатанд өмгөөлөгч авахын ач холбогдлыг сайн ухаардаггүй, төлбөрийн чадваргүй тул өмгөөлөгчөө өөрөө сонгох бололцоогүй байх тохиолдол цөөнгүй байсаар байна. Өмгөөлөгчийг шүүх хуралдааны өмнө шүүхээс томилдог практик тогтсон бөгөөд ихэнх тохиолдолд өмгөөлөгч нь хэргийн талаар шүүх хуралдааны өмнөхөн сонсож, шүүх хуралд сайтар бэлтгэх хугацаа олгогдогддоггүй байна. Энэ практик дээр хүүхэд бүр өмгөөллөөр хангагдах эрх тэр бүр хэрэгжихгүй байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр насанд хүрээгүй хүний өмгөөлөх хөлс нь бага тул өмгөөлөгч нар цааргалдаг, төлбөрийн чадваргүй хүмүүст хуульзүйн туслалцаа үзүүлэх зардлыг шүүхүүдэд хуваарилан төлдөг, түүнийг шүүхээс бусад зардалд зориулах элбэг байгаа механизм нь

²⁰ ШШБЕГ – ын дүн бүртгэлээс 2004 оны 3 сар

²¹ Хүний эрх эрх чөлөөний тухай илтгэл ХЭҮК 2003



өмгөөлөгчийн шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд үйлчилгээ үзүүлэх хөрөнгийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлүүд болсон хэвээр байна.

- Хүүхдийн мэргэшсэн өмгөөлөгчдийг бэлтгэх, тэдэнд зориулсан гарын авлага, материал бэлтгэх, насанд хүрээгүй хүүхэд, тэдний эцэг эхийн өмгөөлөл хэрхэн сонгох талаар практик мэдээллээр хангах, ТББ " ыг өмгөөлөлд идэвхтэй татан оролцуулах, өмгөөлөгчөө сонгох эрхийг нь бататгах, өмгөөллийн бие даасан байдлыг хангах
- Анх удаагаа онц хүнд биш хэрэгт холбогдсон хүүхдүүдэд хорихоос өөр ял оноох хуулийн заалтыг өргөнөөр ашиглах, харин хүүхдүүдэд ажил мэргэжилтэй болох, нийгэмд хөлөө олон амьдрах чадвар бүхий шинэ зан үйлээр төлөвшүүлэх урт хугацааны тасралтгүй амьдрах ухаан, сэтгэл заслын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг бий болгох

3.4.4. Хүүхдийн хорих ангид ял эдэлж байгаа хүүхдүүдийн байдал

Монгол улсын Засгийн газраас 1999 онд Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр батлан, Цагдаагийн хүүхдийн хэлтсийг Хүүхдийн ба түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс болгон нэг үйл ажиллагааны чиглэлийг өөрчилжээ. 2004 онд уг хэлтсийн нэр Олон нийтийн харилцах хэлтэс болон өөрчлөгдсөн байна. Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрт хараа хяналтгүй хүүхдүүдийг хамгаалах болон тэдэнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх асуудал мөн тусгагдсан байна. ЦЕГ - аас" Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлаарх үндэсний чуулга уулзалт" - ыг 2003 онд зохион байгуулсан байна.

Хүүхдийн хорих ангийн дарга Д. Цээсэд хурандаа мэдээлснээр:

"Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр 1000 – 1500 хүүхэд гэмт хэрэгт холбогддог. Үүнээс 150 орчим хүүхэд хорих ял авч байна. Эндээс харахад шүүхээр ял шийтгүүлсэн хүүхдийн 10 гаруй хувьд хорих ял оноодог бөгөөд насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангид жил бүр 150 - 200 хүүхэд ирдэг байна. Мөн жилд 120 Хүүхэд суллагддаг. 30-40 орчим хүүхэд насанд хүрэгчдэд шилждэг. 1-3 жилийн ялтай хүүхдийн 90 хувь нь 50 Хувийг нь эдлээд гардаг.

80 хувь нь 16 - 17 насны хүүхэд байна. 30 хувь нь бичиг үсэггүй, 50 - 60 хувь нь сургууль завсардсан хүүхдүүд байна.

Шийтгэгдсэн хэргийн төрлийн 70 хувь нь хулгай, эдгээр хүүхдийн ихэнх нь амьжиргааны түвшин доогуур амьралтай хүүхдүүд байхад 30 хувь нь хүн амь, танхай, дээрэм, булаалт, залилан хийсэн. Эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь боломжийн амьдралтай айлын хүүхдэд байдаг нь ажиглагдсан.

Уг хүүхдүүдийн нийгэмшүүлэн төлөвшүүлэхэд дараах арга хэмжээ авч байна:

- ЕБС - ын 32 -р сургуультай гэрээ хийж, ял эдэлж буй хүүхдүүдэд бичиг үсэг сургах, ерөнхий эрдэм сургах
- Дэг журамтай амьдралд төлөвшүүлэх
- Мэргэжлийн чиг баримжаа олгох
- Хууль эрхзүй таниулах



- Нийгмийн ажлтан, сэтгэлзүйчийн орон тоотой болсон
- Гэм бурууг нь ойлгуулахад шашны байгууллагынхантай хамтран ажиллах
- Гарахад 3- 6 сар дутуу байгаа хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгоор Дэлхийн зөн ОУБ -тай хамтарч, "Гэрэлт өргөө " төсөл хэрэгжүүлж, хорих ангийн дэргэд гэрт бие даан амьдруулан итгэл өгч, ажиллах шинэлэг аргуудыг нэвтрүүлж эхлээд байна.
- Хүүхдийн хорих ангийг нээлттэй системийн хэлбэр бий болгох талаар анхаарах
- Хорих ангиас гараад очих хүүхдийн гэр бүлтэй ажиллаж, хүлээж авах орчинг нь бэлдэхэд анхаарах\цаашид хэвийн амьдрах"хөндий зайг арилгах" сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх\
- Наранд байгаа, гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхдүүдийг анхааралдаа авч урьдчилан сэргийлэх ажлыг далайц үр дүнтэй явуулах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.
- Эмэгтэйчүүдийн хорих анги хотоос нилээд зайдуу байрладаг тул тэнд хоригдож буй охидод хөвгүүдийн хорих ангитай харьцуулахад туслалцаа бага очдог байна.²²

3.4.5.Хараа хяналтгүй хүүхдүүд

ЦЕГ- ын Хүүхдийн цагдаагийн албаны 2004 оны 3 сард мэдээлснээр албан ёсоор бүртгэгдсэн 50 орчим хүүхэд гудамжинд одоогоор тэнэж байгаа хэмээн мэдэгдэв.

Хаяг тогтоох төвд 2004 онд 903 хүүхэд бүртгэгдэж, 350 орчим хүүхдийг Амгалан дахь Хүүхдийн хөдөлмөр сургалтын тусгай төв, Дэлхийн зөн, Бадамлянхуй төв, Ханын материалд байдаг Амьдрах ухаан сургалт хүмүүжлийн төвүүдэд шилжүүлж, үлдсэн 500 орчим нь өөрийн гэр бүл, халамжийн төвүүдэд хүргэгдсэн ч тэндээсээ оргож, тэнэсээр тус төвд давтан ирсээр байдаг байна. Мөн дээр дурдсан 4 халамж сургалтын төвөөс бусад нь авдаггүй гэж Хаяг Тогтоох шалган хуваарилах төвийн эмч, аргазүйч Ш.Энхмаа мэдээлсэн юм.Халамжийн төвүүдэд одоогийн байдлаар нийт 1100 хүүхэд байгаа бол 140 нь Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвд үлдсэн 200 - гаад хүүхдүүд Дэлхийн зөн,Бадамлянхуа,Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай төвүүдэд байгаа гэж үзэхэд 700 гаруй хүүхдүүдийн хаанаас олж авч байна вэ гэсэн асуулт гарч ирсэн юм. Ингээд бусад зарим төвүүдийн ажилтнуудтай уулзахад ихэнх тохиолдолд гэр бүл нь хүнд амьдралтай,эцэг эхийн хараа хяналт сул, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх чадваргүй, сургууль завсардсан гэх мэт шалтгаанаар тухайн харьяалагдах газрын хороон даргын тодорхойлолтоор авдаг байна.Гэвч тэр бүр ийм боломжийг тулгах хэцүү байдаг учир нь 70 - 80 орчим нь тодорхой оршин суух хаяггүй,бичиг баримтгүй гэсэн зөрчилтэй хүүхдүүд ирдэг нь түгээмэл байдаг байна.

Улсын хэмжээнд нийт хараа хяналтгүй хүүхдийн тоо 1999 - 2001 онуудын байдалтай харьцуулахад 2004 онд хоёр дахин буурчээ.Гэхдээ хараа хяналтгүй

²² Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд НҮБ - ын Хүүхдийн Сан, 2002



хүүхдүүдийг илрүүлэн цуглуулах ажиллагаа голдуу тодорхой тогтоон байршил, газруудад давтан зохион байгуулагддаг тул хүүхдүүд тэр үеэр хөноглож байсан газраасаа дайжин явдгаас шинээр бүртгэгдсэн хүүхдийн тоо тэр бүр бодит байдлыг илэхийлэхгүй байж болох юм. Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа Хаяг тогтоон шалган хуваарилах төвд шинээр ирсэн хүүхдийн тоо 1999 - 2004 онуудын хугацаанд буураагүй, харин мөн оныхтой харьцуулахад 38 хувиар өссөн байна.

2004 оны байдлаар хараа хяналтгүй хүүхдүүдийн 72 хувь нь нийслэлд байгаа тул тэдгээрт чиглэсэн үйл ажиллагаа хотод илүүтэй төвлөрч байна. Эцэг эхийн хараа хяналтаас гаран урт богино хугацаагаар гэр орноо орхин гол төлөв гудамж, орц траншейд амьдарч буй хүүхдүүдийг илрүүлэх, шилжүүлэх, халамж үзүүлэх үйлчилгээг дор дурдсан улсын 8, гадаадын 24 халамжийн төвүүд үзүүлж эдгээрийн 23 нь нийслэлд байна.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 09 дүгээр тушаалаар 13 хүний бүрэлдхүүнтэй салбар дундын ажлын хэсэг байгуулан 2004 оны 2 дугаар сард нийслэл хотод үйл ажиллагаагаа явуулж буй 30 халамж, асрамжийн төвийн үйл ажиллагаатай танилцахад дээрх төвүүдэд нийт 1100 гаруй хүүхэд байрлаж байсан. Дээрх төвүүдээс улсын төсвөөс санхүүждэг 5, Хүүхэд асран хүмүүжүүлэх төв, тус төвийн цэцэрлэг, Нялхсын клиник сувилал, Хөдөлмөр хүмүүжил сургалтын төв, Хаяг тогтоох шалган хуваарилах байр, Германы Хелп Интернэшнл байгууллагын санхүүжилтээр 4, Английн хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр 3, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын санхүүжилтээр 3, Японы энтайвны салхи байгууллагын санхүүжилтээр 2 төв тус тус багтаж байна. Тэрчлэн олон улсын СОС Киндердорф байгууллага, АНУ - ын Нью Лайф Крисчиан байгууллага, Ватиканы төлөөлөгчийн газар, Оюунтүлхүүр сан, Кристиана Нобелийн сан, Дани - Монголын хамтарсан хүүхдийн халамжийн сан, "Айванхоу Майнз" буяны байгууллага, Солонгосын Кайнония Коммюнити байгууллага тус тус нэг халамжийн байгууллага, АНУ-ын иргэн Жон Хайт 2 асрамжийн газар, Японы иргэн Касуго, Юуко, Германы иргэн Рут Ибнер, Германы иргэн Беста нар тус бүр нэг асрамжийн газар санхүүжүүлэн ажиллуулж байна.

2004 онд НХХЯ - халамжийн төвүүдийн ажлыг дүгнэхдээ: Халамж асрамжийн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр явуулах, хүүхдүүдийг эцэг эхтэй нь тохирон халамжийн төвд авах, хүүхдийг гэр бүлээс нь аль болох хөндийрүүлэхгүй байж, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх гэсэн төрийн бодлоготой зөрчилдөж байна. Төвийн ажилтнууд хүүхэдтэй ажиллах дадлага ур чадваргүй байх, хүүхдийг асрамжийн төвөөс бусдын асрамжинд хууль бусаар шилжүүлэх, хүүхдийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, шашны хурал цуглаан зохион байгуулах, үйл ажиллагааны тайланг төрийн байгууллагад ирүүлэхгүй байх зэрэг дутагдлууд тодорхой хэмжээгээр илэрч байна гэжээ. Гэвч уг танилцах ажил нь бусдад дэлгэрүүлж болох сайн нааштай туршлагаудыг судлаагүй байна.

Асрамжийн газар байрлаж байгаа 1100 хүүхдүүдээс 30 орчим хувь нь улсын халамжийн төвүүдэд, үлдсэн хэсэг нь бусад гадаадын байгууллага хувь хүний дэмжлэгтэй халамжийн төвүүдэд байрлаж байна. Энэ хүүхдүүдээс 43,4 хувь нь эцэг эх асран хамгаалагчгүй хүүхэд, 68,9 хувь нь сургууль завсардсан, 80,5 хувь нь гэр



орны хүнд нөхцлөөс болон асран хамгаалагчгүйн улмаас тэнэдэг гэсэн байна. 60-70 хувь нь хөвгүүд үлдсэн хувь нь охидууд эзэлж байна.


Амгалан дахь Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгал төв 2004 оны 10 сарын 1нд 42 хүүхэд хаяг тогтоохоос хүлээн авч, 12 сарын 15 мөн 30 аад хүүхэд нэмж ирсэн. 2005 ны 2 сарын байдлаар 7 -17 насны 140 хүүхэдтэй байгаа. 1-4 ангиас дээш боловсролын албан бусаар олгож, 50 -р сургуультай гэрээ хийж, 15 хүүхэд албан сургалтанд суралцах шалгалтанд тэнцээд суралцаж байна. 2003 онд 25 хүүхдийг гэр бүлийг нь судалж боломжтой гэж үзээд буцаасан. 2004 онд 8 хүүхэд гэрт нь буцаасан. Эдгээр хүүхдүүд нь гэртээ тогтсон гэнэ. Хүүхдүүд өвөлдөө гайгүй тогтдог, дулаарахаар зарим нь оргох асуудлууд цөөнгүй гардаг. Уг нь хүүхдүүд 1 сар тогтчихоороо оргох нь гайгүй байдаг. Эхний саруудад хүүхдийг дасгаж тогтоох л амаргүй байдаг гэж тус төвийн сургалтын менежер К.Энхтуяа ярилаа.

2004 онд ЦЕГ, АХИСан, Хүүхдийн Цагдаагийн Алба, ИБМТөвтэй хамтран 110 хүүхдийг бичиг баримттай болгосон байна. Гэвч энэ үйл ажиллагаа нь тогтмол биш, Хаяг тогтооход ирж байгаа хүүхдүүдийн 90 гаруй хувь нь ямар ч бичиг баримтгүй байдаг байна. Тэднийг хаягийг тодруулахад гэрийн хаягаа мэдэхгүй, гэрийнхэн нь нүүсэн гэх мэт бэрхшээлүүд гарахын зэрэгцээ бичиг баримтжуулахад төрсөн он сараа мэдэхгүй байх тохиолдол элбэг байдаг байна.

2004 онд НХХЯ - аас Халамжийн төвүүдэд хараа хяналтгүй хүүхдүүдийг байршуулан халамжийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааны стандартыг боловсруулан баталсан байна.

2003 оны 6 сард Засгийн газрын " Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 138 " р тогтоолоор нийслэлийн Сонгино Хайрхан дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн төвд 17 --24 насны хараа хяналтгүй хүүхэд, орон гэргүй тэнэмэл амьдралтай насанд хүрсэн залуучуудыг байршуулан хүүхдүүдийг амьдрах ухааны сургалтын төвд хамруулж үйл ажиллагаагаа явуулах болсон байна. Энэ нь 1990 оноос хойш тэнэсэн хүүхдүүд өнөөдөр насанд хүрчихсэн, хоорондоо гэр бүл болж хүүхэдтэй болсон ч өнөөг хүртэл тэнэмэл амьдралаасаа салаагүй, нийгэмшин төлөвшөөгүй байгаа эмзэг суудалд мэдрэмжтэй хандаж буйгаараа шинэлэг алхам болжээ.

Мөн Хаяг тогтоох болон халамжийн төвүүд гэрийн хаяг, аав ээжийнх нь сургийг гаргасан л бол шууд хүргэж өгдөг, дараахан нь хүүхэд гэрээсээ дахин явчихсан байгаа эргүүлэгнээс гарах гарц хайж, гэр бүлийн амьдралын нөхцөл байдлыг судалж, эцэг эхийн ахуй амьдралд туслалцаа үзүүлж, гэр олгох, амьдрах ухааны сургалтуудад хамруулах, хүүхэд гэр бүлдээ амьдрах бололцоотой гэж үнэлгээ хийсэн тохиолдолд хүүхдийг гэрт буцаах гэх мэт нааштай оролдлогуудыг хийж эхэлж байна.



3.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

Нийгмийн хамгаалалтай холбогдсон хууль тогтоомжинд " тахир дутуу хүн " гэсэн нэр томъёог хэрэглэдэг. " хөгжлийн бэрхшээлтэй иргэд" гэдэг нэр томъёог хэрэглэхээр болж байгаа ч одоогоор эрхзүйн хүрээнд хэрэглэж эхлээгүй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үндэсний хэмжээний судалгааг ҮСГ - аас хийсэн. Одоогоор судалгааны дүг хараахан гараагүй байна. 1998 оны байдлаар Монгол улс нийт Хүн амын 4.8 хувь буюу 115 мянган хүн дутуу гэсэн албан ёсны тоо байна. Гэгээрлийн яамны \ 1998 оны үеийн нэрээр\ мэдээгээр сургуулийн насны хүүхдийн 8 хувь нь буюу 34 мянга гаруй хүүхэд тахир дутуу байгаагийн 5.8 хувь нь тусгай сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд, 31 хувь нь ердийн ЕБС - д хамрагддаг, бусад нь сургуулийн гадна байна.²³ *

БСШУЯ - ны мэдээгээр 2002 оны байдлаар Монгол улсад нийт 40000 орчим хүүхэд ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.²⁴ Эндээ үзэхэд тахир дутуу хүүхдийн тоо нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагддаг тахир дутуу хүмүүсийн талаарх тоо мэдээ насаар зааглагдан хамрагдан гардаггүй тул чухам хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгмийн халамжинд хамрагддаг, тэдний тоо өсч, буурч ирсэн эсэх, мөн хэд хүүхэд хэний зүгээс хүчирхийлэл дарамтлал, алагчлалд өртдөг талаар хийгдсэн судалгааны тоо баримт байхгүй байгаа учир энэ талаар дүгнэлт хийх боломжгүй байна.

Улаанбаатар хотын 9 дүүргийн нийт тахир дутуу болон эмгэг согогтой 0-18 насны хүүхдүүдийн судалгаанаас үзэхэд нийслэлд нийт 1492 тахир дутуу хүүхдүүд байгаагийн \хөдөлгөөний, сэтгэцийн, харааны, сонсгол хэл ярианы бүрэн чадамжгүй болон оюуны хомсдолтой хүүхдүүд 54.4 нь эрэгтэй хүүхдүүд байгааг үзвэл энэ хоёр судалгаанд хүйсийн харьцаа ойролцоо гарсан нь үндэсний байдлыг илэрхийлж болох юм. Насны бүлгээр авч үзвэл 0 - 8 насны хүүхдүүд 27,3 хувь, 9-15 насны хүүхдүүд 49,5 хувь, 16 -18 насны хүүхдүүд 12.7 хувийг тус тус эзэлж байна.

Тахир дутуу хүүхдийн 66.4 хувь нь орлогын эх үүсвэргүй болон өрхийн нэг гишүүд ногдох сарын дундаж орлогын хэмжээ нь Засгийн Газраас тогтоосон ядуурлын шугамаас доогуур өрхөд амьдарч байна.

Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тахир дутуугийн байдлаар авч үзвэл 28.8 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 27 хувь нь сонсгол хэл ярианы эмгэгтэй, 25 хувь нь оюуны хомсдолтой, 12.5 хувь нь харааны гажигтай, 6.6 хувь нь сэтгэцийн гажигтай хүүхдүүд байна. Хүүхдүүдийн тахир дутуу болсон үндсэн

²³ Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Засгийн Газрын 1998 оны 202 - р тогтоолын 1-р хавсралт

²⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн үйлчилгээний байдлын судалгаа, 2003 он, " Мон Эдүк Консалтинг" ХХК



шалтгаануудад эм хорт бодисын хордлого, төрөхийн хүндрэл болон холбооны төлөөлийн дутагдал орж байна. Мөн ахуйн осол ч нэлээд хувийг эзэлж байна. Хүүхдийн төрөлхийн хөгжлийн бэрхшээл эрт эхэлдэг ч тэр бүр цаг алдсангүй оношлогдоо эрт зөв хийгддэггүй байна. Судалгаанаас үзэхэд төрөлхийн бус шалтгаантай хүүхдийн согог 39 хүүхдээс 27 хүүхдийн хувьд хөгжлийн бэрхшээл нь 0 - 3 насандаа илэрсэн байна. Эцэг эхчүүдийн санхүүгийн чадавхи, хүүхэддээ тавих анхаарал сул, эрүүл мэндийн байгууллага хамгийн чухал үед нь анхаарал алдагдаж байгаа нь хүүхдийн эрт үед нь засан илааршуудах боломж хязгаарлагдаж байгаа нь нэн харамсалтай явдал юм.

Улаанбаатар хотод цэцэрлэгийн насны тахир дутуу хүүхдийн 35.1 хувь нь цэцэрлэгт үүнээс 26.4 хувь нь тусгай цэцэрлэгт голдуу сонсгол болон хэл яриа, харааны согогтой хүүхдүүд байдаг байна.

ЕБС - д 48.8 хувь нь сургуульд хамрагддаг байна. Үүнээс 62.9 хувь нь ердийн сургуульд, бусад нь тусгай сургуульд хамрагдсанаас 10 шахам хувь нь сургуулиас завсардсан байна. Эдгээр хүүхдүүд нь гол төлөв хөдөлгөөний болон оюуны хомсдолтой байна. Хөдөө орон нутагт тахир дутуу хүүхдүүд сургуулийн гадна үлдэх явдал түгээмэл байгаа хэвээр байна.

Улаанбаатарт байгаа хүүхдийн 84.2 хувь нь эцэг эхийн асрамжинд, бусад нь ах эгч, хамаатан садан төрөл садныхаа болон бусад хүмүүсийн асрамжинд амьдарч байна. Тахир дутуу хүүхдүүдийн 78.2 хувь нь эцэг эхийн анхаарал халамжийг сайн гэж үзсэн байна, дөрвөн хүүхдийн нэг нь халамж асаргаа сул гэж хариулсан байна.

Улаанбаатар хотод амьдарч буй хүүхдийн зөвхөн 28 хувь нь нийгмийн халамжинд хамрагдсанаас 61.6 хувь нь байнгын тэтгэвэр тэтгэмж авдаг, 17.3 хувь нь нэг удаагийн тусламж авсан байна.

Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хуулинд зааснаар нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх нь хөдөлмөрийн чадвараа алдсан болон тэжээгч нь нас барсан, эсвэл тэжээн тэтгэх хүнгүй болсонтой холбоотойгоор үүсч байгаа бөгөөд мөн хуульд " Байнгын асрамжинд байдаг 16 хүртэлх насны хүүхдэд үзүүлэхээр заасан нь тахир дутуу хүүхдэд үзүүлэх нийгмийн зохих халамж үйлчилгээг хязгаарладаг байна. төрөлхийн бус шалтгаантай, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдүүд тэдний өрхөд үзүүлэх үйлчилгээ ийнхүү буурсан байна. Нөгөөтэйгүүр нийгмийн халамж, асрамжийн сангаас үзүүлэх, нийгмийн халамж үйлчилгээг суралцаж байгаа бол 19 хүртэлх, суралцаагүй бол 16 хүртэлх үзүүлэхээр заасан нь 18 нас хүртэлх бүх хүүхдийг хамгаалахаар заасан НҮБ - ын ХЭЖ болон Монгол улсын хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн заалттай нийцээгүй, бодит байдалд тахир дутуу хүүхдийн сургуульд хамрагдах боломж хомс байгааг харгалзан үзээгүй нь сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд дээр нь нийгмийн халамж хүртэх боломж нь хязгаарлагддаг байна.

Хүүхдийн 49 хувь нь групп тогтоолгох, тэтгэлэг тэтгэмж авах, 18.6 хувь нь сувилуулах, 11.2 хувь нь тусгай асрамж авах шаардлагатай байна гэжээ. Түүнчлэн тахир дутуу хүүхдүүд амьдрах дадал хэвшилд суралцах, нийгэм хамт олны дунд



орох, эцэг эхчүүдээ хүүхдээ хэрхэн асрах талаар зөвлөгөө сургалтанд тааруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Хөдөө орон нутагт мэргэжлийн хүүхдийн эмч байдаггүй, тархины саажилттай хүүхдэд зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хангалтгүй, чухал шаардлагатай эмийг удаан хугацаагаар хэрэглэж чаддаггүйгээс өвчин газар авахад хүрдэг, амьгийн нэгдсэн эмнэлгийн эмч нар сургалтанд хамрагдах нь ховор, сум аймгийн төвүүдэд харааны согогтой хүүхдүүдэд нүдний шил тааруулах, чанартай нүдний шил зардаг үйлчилгээ хомс байдаг байна. Түүнчлэн хүүхдийн нөхөн сэргээх эмчилгээ хийх зориулалтын тоноглол, мэргэжилтэн хөдөө орон нутагт байдаггүй.²⁵

Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан 10 - 18 насны тахир дутуу хүүхдүүдийн бараг тал хувь нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээ байна. Тахир дутуу хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар цаашид судалгааны хүрээг өргөтгөх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрийн хүрээнээс гадна найз нөхөдтэй болоход бусад хүүхдүүдийн эцэг эх нь дургүйцдэг явдал гол бэрхшээл болдог гэнэ. Ер нь тахир дутуу иргэдийг гадуурхах, ялгаварлах хандлага олон нийтийн дунд байсаар байна. Хүчирхийллийн харилцаа давмгайлсан гэр бүлд өсөж торниж буй хүүхдүүд бэртэн гэмтэж тахир дутуу болох, айснаас болж хэлгүй болох тохиолдол ХЭҮТ - Хамгаалах байрны эмэгтэйчүүд хүүхдүүдийн дунд хийсэн судалгааны баримтанд байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн үйлчилгээний байдлын судалгаа, 2003 он, " Мон Эдук Консалтинг" ХХК



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

Дүгнэлт

4.1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлын эрхзүйн орчин:

Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар уялдаа холбоо, шат шатны үр дүн, хариуцлага тооцох, мониторингийн тогтолцоо үгүйлэгдэж байна.

Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах талаар Монголын хууль тогтоомжинд олон улсын Ковенцийн заалт, гэрээнд нийцүүлэн тусгаж, түүнийг хэрэгжүүлэхэд Үндэсний бодлого хөтөлбөрт тусгайлан багтаасан байна. Үүнээс үзэхэд эрхзүйн орчин бүрдсэн гэж үзэж болох талтай ч хэрэгжих шатандаа хангалтгүй хэлбэр төдий байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд хуулийн байгууллагад хандах нь тун цөөн хувийг эзэлдэг бөгөөд энэ хэрэг нь ихэнх тохиолдолд хүнд бэртэл, амь насаа алдах эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж ноцтой байдалд/жирэмсэн болсон, өнгөний өвчин авсан, гэр бүлийн гишүүд нь мэдсэн, айлган сүрдүүлэлт гэх мэт/ орсон тохиолдолд шүүхэд хандаж байна.²⁶

Хэдийгээр манай хууль тогтоомж, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах эрхзүйн орчин олон улсын жишигт нийцэж байгаа мэт боловч амьдрал дээр хэн, хэрхэн яаж, асуудалд хөндлөнгөөс оролцож, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх талаар нарийвчилсан порцессийн журам, үйлчилгээний стандарт дутмаг байна. Хүүхдийг хамгаалах үйлчилгээ нь хуулийн болон халамжийн газар ирсэн хүүхдүүдэд дөнгөж хүрч, зөвхөн захиргааны болон халамжийн арга хэмжээнд гол хүчээ төвлөрүүлж байна. Урьдчилан сэргийлэх, нийгмийн нөхөн сэргээх яаралтай болон дунд хугацааны ажлыг салбар дундын оролцоог уялдуулан хэвийн амьдралд оруулахад дэмжих нийгэм эрхзүйн үйлчилгээний чадавхи сул байна.

Манай улсын соёл зан заншил, хүн ам, дэд бүтэц, нийгэм эдийн засгийн тогтолцоог харгалзан үзээгүй нь хуулийг "хүчин мөхөс" болгож байгааг эргэн харах хэрэг хэрэгтэй байна.

Хүүхдийн чиглэлээр мэргэшсэн байцаагч, өмгөөлөгч гэх мэт хуулийн ажилтнууд магадгүй гэр бүлийн дагнасан шүүх, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хэлтэс байхгүйгээс хүүхэд хэмээх "эмзэг" хохирогч, гэмт хэрэгт холбогдогчдын асуудлыг шийдэхэд " хайнга " хандаж буйд хүүхдийн асуудал хариуцсан төрийн албан хаагчдын ихэнх нь хүлээн зөвшөөрч байгаа юм.²⁷

Хуулийн байгууллагын ажилтнууд хүүхэдтэй ажиллах, мөрдөн байцаалт явуулах, тэдний өргөдөл гомдлыг барагдуулахдаа хүүхдийн онцлогийг харгалзан үзэх чадвар дутмаг, гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх, аюулгүйн түвшинг тодорхойлох, хэрэгцээг нь мэдрэх мөн түүнчлэн хүчирхийллийн талаар хуучинсаг хандлага нөлөөлөх зэрэг нь хүүхдийн эрхийг сэргээхэд саад тотгор болж, хохирогч хүүхэд болон тэдний ар гэрийнхэн залхах явдал байсаар байна.

²⁶ UNIFEM TRUST FUND 3 Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрхзүйн орчин баримтат хуудас 2002 он

²⁷ Төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаас



Нийгмийн халамжийн салбарын бүтцийн шинэчлэл, өөрчлөлтийн үндсэн гол асуудал тусгагдсан бөлөвч завсрын дунд шатны стратеги байхгүй байна. 2003 онд батлагдсан төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуульд улс аймгийн болон Улаанбаатар хотын захиргааны бүтцийг өөрчлөх, цомхотгох асуудал тусгагдсан байсан.

4.3.: Хүүхдийн эсрэг хүчирхийлэл судлагдсан байдал, хүчирхийллийн илрэх хэлбэрүүд

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн тархац, тандалтын судалгааны талаар үндэсний статистикийн тоо баримтанд байхгүй байна. Тухайлбал :ЦЕГ, Эмнэлгийн тусламжийн удирдах газар болон гэмтлийн эмнэлэгт хүчирхийллийн улмаас бэртэж гэмтэж ирсэн хүүхдүүд хэний зүгээс хаана, ямар байдлаар илүү өртөж байна гэсэн тоо баримт гарах боломжгүй байдаг байна. \Хавсралтаас 4, 5 үзнэ үү \ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдал үндэсний хэмжээнд, хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт нөлөөлөхүйц дорвитой судалгаа хийгдээгүй байна. Энэ байдал нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд хаана, хэн рүү илүү анхаарлаа хандуулах талаар оновчтой стратеги боловсруулахад бэрхшээл учруулж, " барьцгүй" болгож байна.

Монгол улсад хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар үндэсний хэмжээний статистик мэдээлэл хязгаарлагдмал байна. Үүнийг дараах шалтгаанаар тайлбарлаж болох юм :

- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал Үндэсний статистикийн хүрээнд багтаагүй,
- Хүүхдийн эсрэг нуугдмал зөрчлүүдийг өрхийн болон түүвэр судалгаагаар гаргаж ирэх боломж муутай
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, дарамт зэрэг хүүхдийн эрхийн зөрчиж буй асуудлууд гол төлөв далд нуугдмал байдалд үйлдэгддэг
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт дутмаг байдгаас эл асуудлыг мэдээлэх олон нийтийн хараа хяналт, оролцоо хангалтгүй
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд төр нийгмийн үйлчилгээ ямар хариу арга хэмжээ авсан хяналтын талаарх хяналт, мэдээллийн тогтолцоо байхгүй
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хувь нь гэр бүл, сургууль, дотуур байр зэрэг хүүхдийн амьдран байгаа орчны хүрээнд гардаг тул хүүхэд өөрийн болон гэр бүлийн нэр төр, багш, анги хамт олны зүгээс ирж болзошгүй хариу дарамтлал зэргээс болгоомжлон мэдээлдэггүй зэрэг шалтгаануудыг дурдаж болно.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл түүний судлагдсан байдлыг авч үзэхэд энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагууд түлхүү хийдэг байна. Хийгдсэн судалгаануудын ихэнх нь тодорхой зорилтот бүлгийг явцуу хүрээнд хамарч хийсэн тул үндэсний хэмжээнд төлөөлөх чадвар сул байдал ажиглагдаж байв. Энэ чиглэлийн судалгааны сан байдаггүй нь 30 " аад судалгаа хийгдсэн гэж Хүүхдийн төлөө үндэсний Хороонд бүртгэгдсэн ч эх сурвалжтай нь танилцах гэтэл ихэнх нь олдохгүй болсон байлаа.



Насанд хүрээгүй хүүхдүүд болон тэдний эцэг эх байцаан шийтгэх үйл ажиллагааны аль болохоор эрт шатанд өмгөөлөгч авахын ач холбогдлыг сайн ухаардаггүй, төлбөрийн чадваргүй тул өмгөөлөгчөө өөрөө сонгох бололцоогүй байх тохиолдол цөөнгүй байсаар байна. Өмгөөлөгчийг шүүх хуралдааны өмнө шүүхээс томилдог практик тогтсон бөгөөд ихэнх тохиолдолд өмгөөлөгч нь хэргийн талаар шүүх хуралдааны өмнөхөн сонсож, шүүх хуралд сайтар бэлтгэх хугацаа олгогддоггүй байна. Энэ практикт хүүхэд бүр өмгөөллөөр хангагдах эрх тэр бүр хэрэгжихгүй байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр насанд хүрээгүй хүний өмгөөлөх хөлс нь бага тул өмгөөлөгч нар цааргалдаг, төлбөрийн чадваргүй хүмүүст хуульзүйн туслалцаа үзүүлэх зардлыг шүүхүүдэд хуваарилан төлдөг, түүнийг шүүхээс бусад зардалд зориулдаг механизм нь өмгөөлөгчийн шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд үйлчилгээ үзүүлэх сонирхлыг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлүүд болсон хэвээр байна²⁸.

4.2. Бодлого хөтөлбөрийн чиг хандлага, хэрэгжилт

Гэр бүлийн дэмжих болон урьдчилан сэргийлэх дэмжих туслалцаа үзүүлэх үйлчилгээний механизмыг боловсронгуй болгоход ХЭК-ийн нөлөө бага байсан. Үндэсний хууль тогтоомж, бодлогыг ХЭК - д нийцүүлэн өөрчлөн шинэчлэх явц идэвхтэй явагдаж байгаагийн зэрэгцээ манай улсын яамд, орон нутгийн захиргаад олон тушаал, журам шинэчлэн баталж байгаа нь хүүхэд гэр бүлд чиглэсэн үйлчилгээний хөгжил хангамжийг улам сарниулсаар байна. Хүүхдийн эрхийг хамгаалах хууль батлагдсан нь ХЭК - ыг хэрэгжүүлэх анхны алхам болсон ч хэрэгжүүлэх арга замын тогтолцоог зохицуулаагүйгээс түүний нөлөө хязгаарлагдмал байна. Энэ хуулиар хороо дүүргийн нийгмийн ажилтанд хариуцуулахаар заасан боловч нийгмийн халамж үйлчилгээг оновчтой зохион байгуулах явдал энэ хүрээнд боловсронгуй болж чадаагүй, бодит байдалд эрсдэлтэй "эмзэг" хүүхдүүдтэй хүүхдийн байцаагч нар голчлон хариуцсан хэвээр байна. Гэмт хэрэгт холбогдсон, хараа хяналтгүй хүүхдүүд, сургууль завсардсан, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн хохирогч зэрэг "эрсдэлтэй" хүүхэдтэй холбоотой асуудлыг зохицуулах, уламжлал, туршлага байхгүй учраас засан хүмүүжүүлэх, ил шийтгэх, хувийн хяналт гэх зэрэг захиргааны тогтолцоогоор тодорхойлогдож байна. Холбогдох байгууллагуудын хяналт, халамжинд шилжүүлэх эцсийн арга хэмжээ байхын оронд хамгийн түрүүнд авдаг арга хэмжээ болоод байна. Тухайлбал:

Хүүхдийн хаяг тогтоох шалган хуваарилах төв нь нийгмийн ажилтангүй, хүүхдийн сургалт хүмүүжлийн ажил хангалтгүй явагдаж байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт "хүүхэд гэр бүлдээ өсөж хүмүүжих эрхийг" хэрэгжүүлэхдээ гэр бүлд тулгуурлах бодлого баримтлахыг эрмэлзсэн байна. Гэвч "эрсдэлтэй" хүүхдүүдийг төвлөрсөн байгууллагад тулгуурласан халамжийн загваруудыг дэмжсэн хэвээр байна. Үүнд үрчлэх, бусдын халамжинд түр шилжүүлэх явдал ч хамаарна.

²⁸ Хүүхэд хамгааллын байдал UNICEF Монголмаа draft 2005



Өнөөгийн байдаар хийгдсэн судалгаа, баримт мэдээллээс үзэхэд түүхийн эсрэг хүчирхийлэл гэр бүлийн хүрээнд хамгийн түгээмэл оршиж дараагийн шатлалыг сургуулийн орчин, үе тэнгийхний хүрээ эзэлж байна.

Хараа хяналтгүй хүүхдүүдийн дунд овгийн зохион байгуулалтай шатлан дарангуйлах ёс ноёлж, гэмт хэрэгт татан оруулах, охидоо хүчиндэх, худалдах, солих гэх мэт үзэгдлүүд "тогтсон ёс" мэт болсон байдаг байна.²⁹ 1990 оноос эхлэн тэнэсэн хүүхдүүд өнөөдөр насанд хүрч, хоорондоо гэрлэн хүүхэд төрүүлэх, удам дамжсан гудамжны гэр бүл бий болох, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт татан оруулах зэрэг нийгэмд дарамт учруулах гэмт хэргийн томоохон бүлэг бий болсон гэдэгт санаа зовниж байгаагаа онцлон дурдаж, энэ асуудалд анхаарал хандуулж, тэднийг зөв зан үйлд төлөвшүүлэх нийгмийн ажлыг тохирох арга барилыг сонгож, дорвитой ажил хийх нь зөв бодлого, урт хугацаа, ур чадвар шаардсан ч хүүхдийн өсөн хөгжиж буй нийгмийн орчныг эрүүлжүүлэхэд чухал нөлөөтэй үзүүлэх ажил болно хэмээн тэмдэглэж байсан.³⁰

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл тэдний хамгийн таатай, хязгааргүй хайрлагдах гэр бүлийн орчиндоо, эцэг эх, хойд эцэг эх, ах эгч нарынхаа зүгээс сэтгэл санааны болон биеийн хүчний дарангуйлалд өртөж байна. Тэд гэр бүлийн хүчирхийллийн золиос, мөн гэрч болж, бие сэтгэлийн шарх авч байна. Хүүхдүүд гэр бүлдээ ялгаварлан гадуурхагдах, гутаан доромжлуулах, хүний ёсноос гадуур харьцах, нэр төрийг нь гутаах, аюулгүй орчинд амьдрах салшгүй эрх нь зөрчигдөж, эрүүл мэнд сэтгэл санаагаар хохирч, гэрээсээ дайжих, сургууль завсардах, найз нөхдөөсөө хөндийрөх, хичээл сурлагандаа муудах, гадуур тэнэх, гэмт хэрэгт холбогдох, гудамжинд танихгүй хүмүүсийн хүчирхийлэлд өртөх, улмаар амь наснаа алдах зэрэг хор уршгийг ар араасаа дагуулан хохирсоор байна.

Сургуулийн орчинд багш нар хүүхдүүдийг дарангуйлах, алагчлах, нэр төрийг нь гутаах, хүүхдийн сурлага хүмүүжил дордоход илүү анхаарал тавихын оронд өөр сургууль руу шилжүүлэх, сургуулиас хөөх зэрэг хандлага, зан үйлдэл гаргах явдал хөдөө орон нутагт ч, нийслэлд ч түгээмэл байсаар байгаа нь хүүхдийг сургууль, анги хамт олныхоо дунд байх сонирхолгүй болгох, завсардахад сөрөг нөлөө үзүүлж байна.

Сургууль хамт олны орчинд үе тэнгийхний сөрөг нөлөөнд архи уух, тамхи татахыг шаардах, мөнгө нэхэх, хүчиндэх\ автах, дарамтанд өртөж, зодуулж бэртэж гэмтэх, гэмт хэрэгт татагдан орох зэрэг үзэгдэл сургуулийн орчинд байсаар байгааг анхааралдаа авах шаардлагатай байна.

Эцэг эхчүүд болон багш нар хүүхдийн нас насны хөгжлийн онцлогийг ойлгож, тухайн нөхцөлд хүлээцтэй хандах тэвчээртэй харьцаж, ойлголцох чадвар дутагдаж байдаг нь судалгааны зарим баримтаас харагдаж байна.

Халамжийн газар амьдарч, суралцаж байгаа хүүхдүүд үе тэнгийн болон ахмад хүүхдүүдийн дарамтанд өртөх явдал байсаар байна.

Бэлгийн хүчирхийлэлд бага насны болон өсвөр насны охид өртөх явдал түгээмэл оршиж байгааг төрийн бус байгууллага, эмнэлэг, хуулийн байгууллагын дүн бүртгэлээс илэрч байгаа нь ноцтой асуудал юм.

²⁹ Хараа хяналтгүй хүүхэд В.Гучеран UNICEF 2003 он

³⁰ ЦЕГ – ын Халаасны хэлтсийнхэнтэй ярилцсан сурвалжлагаас



Биеэ үнэлэх нь хэдгйгээр орлогын тогтворотой эх сурвалж биеэ үнэлсэн гэр бүлдээ дэмжлэг болох, өөрсдийн амьдралын наад захын хэрэгцээг хангах тодорхой хэмжээний орлого олох зорилгоор олон охид энэ үйл явдалд татагдан орж байна. Яагаад гэвэл тэд эмх замбараагүй, бэрхшээл, зөрчлөөр дүүрэн, эрхийг хамгаалах ямар ч баталгаагүй хүчирхийллийн орчинд амьдардаг байна. Гудамжны амьрал нь тэднийг согтуу залуу, бэлгийн замын халдварт өвчтэй үйлчлүүлэгч, дээрэнгүй цагдаа, биеэ үнэлэгчдийг зуучлагчид, насанд хүрсэн биеэ үнэлэгчидтэй холбож, садар самууныг сурталчилсан сэтгүүл, видеонд зургаа авахуулахад ч бэлэн байдалд оруулдаг нь нууц биш. Насаар бага залуу биеэ үнэлэгчид байнга зодуулж, хүчиндүүлж, баригдаж, тэр ч бүү хэл үйлчлүүлэгчид гэмт хэрэгтний гарт амиа алдах нь байдаг. Биеэ үнэлэх үйл ажиллагаанд нэгэнт орчихоороо түүнээсээ салах нь тэдний хувьд маш хэцүү болдог.³¹

4.4. Халамжийн төвийн үйлчилгээ

Халамжийн төвүүдэд, гэр бүлдээ зүй бусаар ашиглуулсан, үл хайхрагдсан, гудамжинд болон цагдаагийн албан хаагчийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар үр дүнтэй хариу арга хэмжээ авах, тэдний өмнөөс холбогдох газруудтай нөлөөтэй харьцах боломж хомс байна. Ихэнх халамжийн төвүүдэд хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгаалын болон гомдол гаргах журам байхгүй байна.

Зарим халамжийн төвүүд байрлаж буй хүүхдүүдийн гэр бүлтэй ажиллаж, хүүхдийг гэрт нь буцаах ажлыг зохион байгуулж байна. Ийм төрлийн зарим нэг хөтөлбөрүүд амжилт олж байгаа хэдий ч цаашид үргэлжлүүлэн үзүүлэх дэмжлэг хангалтгүй байна. Халамжийг орхиж гарч байгаа залуучуудын хувьд ч ийм байна.

Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах стратегид нийгмийн ажилтны үүргийг түлхүү оруулах төлөвлөгөөг боловсруулах хүрээнд барууны баян орнууд дахь нийгмийн ажилтан Монголын нөхцөлд тохирохгүй гэсэн ойлголт байгаа бөгөөд ямар хэлбэрийн нийгмийн ажилтан манай нөхцөлд тохирох вэ гэсэн асуудалд маргаан өрнөж байна.³²

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд, багш нарын зүгээс хүчирхийлэлд өртөх магадлал жирийн эрүүл хүүхдүүдээс өндөр байдаг гэж тусгай сургуулийн багш нар үзэж байлаа. Зарим сургуулиуд хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, эцэг эхэд нь хүүхэдтэйгээ хэрхэн харьцах талаар зөвлөгөө өгөх төсөл хэрэгжиж байгаа юм байна. Энэ асуудалд анхаарлаа хандуулж, судалгааны нэг хэсгийг чиглүүлэх хэрэгтэй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Тэдний нийгмийн халамжийн асуудалд түлхүү анхаарч, нийгэм сэтгэлзүйн асуудал буюу аюулгүй байх эрх нь зөрчигддөг байгаа эсэх талаар бараг судалгаа хийгдээгүй байна.

³¹ Биеэ үнэлэгчдэд хийсэн судалгаа 1998. Хүүхдийг ивээх сан, Эмэгтэйчүүдийн мэдээлэлсудалгааны төв

³² Хараа хяналтгүй хүүхэд В.Гучеран UNICEF 2003 он




4.5. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүн амын болон хүүхдийн байгууллагын ажилтнуудын мэдлэг хандлага

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүн амын дунд төдийгүй, хүүхэдтэй ажилладаг төрийн албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтан, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдийн ойлголт мэдлэг хандлага хангалтгүй байна. Хүчирхийлэл, түүний хэлбэр, урьдчилан сэргийлэх аргагүй, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө, хүчирхийллийн эсрэг хууль эрхийн актуудын талаар нэгдсэн зөв ойлголтгүй, мэдээлэл сурталчилгаа хангалтгүйгээс хүлээн авч буй мэдээлэл цэгцтэй бус байна. Шийдвэр гаргах түвшний удирдлагууд ч мөн асуудалд өнгөц хандах явдал ажиглагдаж байна.

Хүүхдийг зодох нь хүмүүжлийн арга гэж үздэг хуучинсаг хандлага ч одоо ч түгээмэл оршоор байгаа учир олон нийтийн зүгээс хүүхдийн хүчирхийллээс хамгаалах ухамсар дутмаг байна.

Хүүхдүүд "„хэн нэгэн буруу үйлдэл хийснийхээ төлөө зодуулах нь зүйн хэрэг,,“ гэж үзэх нь нэн түгээмэл оршсоор байна. Хэдийгээр хүүхдүүд эцэг эх, ах эгч, багш нарынхаа хүчирхийлэл дарамтыг эсэргүүцэн, хуулийн болон зохих байгууллагад мэдэгдлээ гэхэд тэднээс "хариу" ирэх дарамтаас эмээж, мэдээлдэггүй байна. Энэ байдал нь хүчирхийлэл далд нуугдмал байхад нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг юм.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



САНАЛ ЗӨВЛӨМЖ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд тогтолцооны гурвалсан стратеги боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч, эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадавхи ноэцийг бүрдүүлэхэд зоримог алхмуудыг хийх нь зүйтэй.

1. *Итгэл үнэмшил, соёл зан үйлийн тогтолцоонд дараах дэвшилтэт шинэчлэл хийх*

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл хүн амын дунд хэвийн үзэгдэл мэт дассан хандлагыг өөрчилж, "үл тэвчих, эсэргүүцэх" нийгмийн ухамсар, сэтгэлзүйг бий болгож, уг асуудалтай тэмцэх олон нийтийн оролцоо санаачилгыг идэвхижүүлж иргэн бүрийн үүрэг болгох,
 - Хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр хүүхдийг хүндэтгэж харьцах, хүчирхийллийн бус хүмүүжлийн аргыг сонгон хэрэглэх зан үйлийг сурталчлах,
 - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хор холбогдлыг таниулах ажлуудыг Төр засгийн бодлогын түвшинд хийх,
- 1.2. Албан болон албан бус боловсролын системд хүчирхийллийн бус харилцааны ур чадварыг амьдрах ухааны сургалтын нэг хэсэг болгон зөв зохистой зан үйлд төлөвшүүлэх хүмүүжлийн сургалтыг түлхүү оруулах, мөн гэр бүлийн болон бэлгийн боловсрол олгож, хүйсийн болон аливаа алагчлалгүй үзлээр хүмүүжүүлэх бодлогыг сургалтын агуулгад багтаах, энэ ажилд сургуулийн нийгмийн ажилтны ажил байдлын торхойлолтонд оруулах,
- 1.2.1. Багш сурган хүмүүжүүлэгчдийн үзэл хандлагыг өөрчилж, сурагчдаа хүчирхийлэн дарамтлах зохисгүй зан үйлдэл гаргасан багшид хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгох,
- 1.2.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах мэдээлэл харилцааны системтэй болж, мөн нууцлалыг хадгалах
- 1.2.3. Цэцэрлэгийн багш нарт хүүхэдтэй ажиллах харилцааны өндөр ур чадварыг эзэмшүүлэх, өндөр шаардлага тавьж, цалин урамшууллын системд өөрчлөлт оруулах,
- 1.3. Олон нийтийн дунд төрийн бус байгууллагууд, сонирхлыг бүлэг, шашны байгууллага, үе тэнгийнхний бүлэг, орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх стратеги боловсруулах,
- 1.3.1. Эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжлийн талаар зөвлөлдөж, туршлагаа хуваалцах уулзалт ярилцлагын клубын үйл ажиллагаа санаачлан зохион байгуулах,
- 1.4. Хүүхдэд нийгэм - эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажилтан нарыг



хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, нөхөн сэргээх талаар нийгмийн орчинтой

нь холбон ажиллах хандлага, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх талаар анхаарах,

2. "Хууль эрхзүйн тогтолцоог хүүхдэд ээлтэй оновчтой болгох"

Хуулийн байгууллагын ажилтнуудын үзэл хандлага сэтгэлгээг шинэчилж, шаардлагатай бүтцийн өөрчлөлийг үе шаттайгаар, дорвитой хийж, холбогдох хууль тогтоомжуудыг эргэн харж, хэрэгжүүлэх механизмыг тодорхой, журам, удирдамжаар стандарчлах, мөн хуулийн хэрэгжилтийн хянах, мониторингийн тогтолцоо, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ажлын үр дүнтэй хийх

2.1. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн цагдаа, өмгөөлөгч, нийгмийн ажилтны боловсон хүчний нөөцийг бий болгохын зэрэгцээ омбудсманы үйлчилгээг хөгжүүлэх ажлыг үндэсний бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай байна. Хэрэв эдгээр боловсон хүчин байхгүй, хүүхдийн эрхийг хамгаалах хуулийг хэрэгжүүлэх субъектүүдийн хандлага, мэргэшил төлөвшөөгүй тохиолдолд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах явдал "эзгүйрч", тухайн албан хаагчийн үзэмжээр шийдэгдэх хэмжээнд явагдаж буй нь " ирээдүйд учирч болох аюулыг дутуу үнэлж буй ноцтой асуудал " юм.

2.2. Цагдаагийн ажилтнуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх одоогийн арга барилыг дахин нягталж үзэх, байгаа нөхцлийг үр ашиггүй зарцуулж байгаа, эрсдэлтэй хүүхдүүдийг гутаасан, гадуурхсан ажиллагааг зогсоох,

2.3. Хаалттай шүүх хуралд гэрчийн мэдүүлэг өгөх бололцоо олгосон аюулгүй орчинг

бүрдүүлэх чиглэлээр шүүн таслах ажиллагааны тогтолцоог шинэчлэх, аливаа шүүн

таслах ажиллагаанд хүүхдийг бие даан төлөөлөх нөхцлийг бүрдүүлэх,

2.5. Хүүхдийн мэргэшсэн өмгөөлөгчдийг бэлтгэх, тэдэнд зориулсан гарын авлага, материал бэлтгэх, насанд хүрээгүй хүүхэд, тэдний эцэг эхийн өмгөөлөл хэрхэн сонгох талаар практик мэдээллээр хангах, ТББ " ыг өмгөөлөлд идэвхтэй татан оролцуулах, өмгөөлөгчөө сонгох эрхийг нь бататгах, өмгөөллийн бие даасан байдлыг хангах,

2.6. Хаяг тогтоох төв болон хүүхдийн байцаагчид олон нийтийн газар, орц хонгил, траншейнд амьдрах хүүхдүүдийг хомроглон цуглуулж, саатуулдагаа больж, зөвхөн шинээр буюу дөнгөж гудамжинд гарсан, хаягдсан, хараа хяналтгүй хүүхдүүдэд гол анхаарлаа хандуулах үүргийг олон нийтийн цагдаагийн байгууллага хүлээх ёстой. Эрүүл мэндийн болон мөн яаралтай тусламж хэрэгтэй хүүхдүүд ч үүнд хамаарна.



2.7. Анх удаагаа, онц хүнд биш хэрэгт холбогдсон хүүхдүүдэд хорихоос өөр ял оноох хуулийн заалтыг өргөнөөр ашиглах, харин хүүхдүүдэд ажил мэргэжилтэй болох, нийгэмд хөлөө олон амьдрах чадвар бүхий шинэ зан үйлээр төлөвшүүлэх урт хугацааны тасралтгүй амьдрах ухаан, сэтгэл заслын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг бий болгох

2.8. Хаяг тогтоох төв, хүүхдийн байцаагчид, дотоод гадаадын ТББ - ууд хараа хяналтгүй, гудамжинд шинээр гарсан болон гараад удаагүй байгаа хүүхдүүдтэй харьцангуй үр дүнтэй ажиллаж байгаа хэдий ч авах арга хэмжээний талаар төлөвлөгөө зохиож, мэдээллийн систем бүрдүүлж ажиллах шаардлагатай байна. Хаяг тогтоох төв, анхан шатны арга хэмжээг зохицуулж, нийгмийн ажилтнууд, гэр бүл, хүүхдэд дэмжлэг үзүүлэх дараагийн шатны тогтолцоонд залгамж холбоо үүсгэх арга хэмжээ авах нь зүйтэй:

- ТББ - ууд өөрсдийн зарчмын хүрээнд олж тогтоосон хараа хяналтгүй гудамжинд шинээр гарч ирсэн хүүхдүүдийн тухай мэдээллийг Хаяг тогтоох төвд өгөх, эсвэл тухайн байгууллага гэр хүүхэдтэй үргэлжлүүлэн ажиллах эсэхээ мэдэгдэх, хэрэв үргэлжлүүлэн ажиллаж чадахгүй бол Хаяг тогтоох төвд шилжүүлэн өгөх зэрэг ажлын уялдаа холбоотой ажиллах зайлшгүй шаардлагатай байна.
- Хүүхэд, сэтгэл эмзэглүүлсэн асуудлаас болж, гэр орноо орхиж байгаа тохиолдолд цаашид авах арга хэмжээ дэмжлэгийг нийгмийн ажилтан болон, холбогдох байгууллагуудын ажилтай уялдуулж, нэг бүрчлэн хэрэг шийдвэрлэх аргаар ажиллах шаардлагатай. Хараа хяналтгүй хүүхдийг Хаяг тогтооход саатууах 14 хоногийн хугацаа нь тэднийг ямар нөхцөлд байсныг, тухайлбал гэр бүл нь зөрчилтэй эсэх, зүй бусаар ашиглагдсан, үл хайхрагдсан эсэх, халамж анхаарлын түвшин, хүчирхийлэл зэргийг тодорхойлоход хангалттай хугацаа юм. Хүүхэд болон ар гэрт нь үзүүлэх байнгын тусламж дэмжлэгийг уялдуулан зохицуудах, гэр оронд нь буцахаас нь өмнө гэрт нь очиж амьдралынх нь нөхцлийг тодорхойлох зэрэг ажлууд ч үүнд хамаарна.
- Хүүхдийг гэрт нь буцаах эрсдэлтэй боловч, түүнийг нийгмийн ажлаар дамжуулан зохицуулж болох бөгөөд хүүхдийн аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх талаар онцгой анхаарах хэрэгтэй юм. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар дээр тулгуурлан хүүхэд, гэр бүлийн харилцааг сайжруулахад нийгмийн ажил чиглэгдэх ёстой. Мөн албан болон албан бус сургалт, хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйлчилгээ болон бусад тохиромжтой хөтөлбөрүүд зэрэг нийгэм-хамт олны доторх сүлжээгээр асуудлыг шийдэх боломжтой юм.

2.9. Хүүхдийг зүй бусаар ашигласан, хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн явдал илэрвэл гэрт буцаах эсэх талаар шийдвэр гаргах шаардлагатай болно. Иймэрхүү тохиолдолд хүүхдээс олон дахин байцаалт авахаас зайлсхийсэн хүүхдэд таатай орчинд захиргааны болон шүүхийн таслах ажиллагаанд хэрэглэх нотлох баримт гаргах, мэдэгдэл хийх боломжийг хангаж өгөх хэрэгтэй. Хүүхэд хамгаалах асуудал



нэлээд хүндрэлтэй тохиолдолд ч хүүхдийг гэрт нь буцаах боломж байсаар байдаг. Цагдаа болон нийгмийн ажилтан хүүхдийг хүчирхийлсэн, мөлжсөн этгээдүүдэд арга хэмжээ авах, тэдний эсрэг хэрэг үүсгэн шалгах шаардлагатай эсэхийг тодорхойлж өгөхдөө:

- Бүх тохиолдолд хүүхдийн нас, ойлгох чадвар, төлөвшилд нийцүүлэн санал бодлыг нь харгалзан үзнэ
- Зүй бус харьцаа, мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд зохих зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ
- Хаяг тогтоох төвд хүүхдийн хурууны хээг авдаг явдлыг зогсоох нь зүйтэй. Энэ нь ямар нэгэн гэмт хэрэг хийгээгүй хүүхдийг доромжилсон, хүүхдийн эрхийг бүдүүлгээр зөрчсөн хэрэг юм.

3. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах нийгмийн халамж үйлчилгээ

Хүүхдийг хүчирхийллээс "хамгаалах халамж үйлчилгээний чадавхи"- ийг бэхжүүлэхийн тулд салбар дундын оролцооны уялдаа холбоог хангах, тухайн чиглэлийн нийгмийн ажилтны үүрэг ролийг тодорхой болгож, холбогдох байгууллагуудтай холбон зохицуулах системийн нэвтрүүлэхийн зэрэгцээ богино, дунд хугацааны үйлчилгээ, гэр бүлтэй нь хамтран ажиллах, зан үйлийг өөрчлөх, нөхөн сэргээх мэргэшлийг эзэмшүүлж, ур чадварыг нэмэгдүүлж, хүн хүчний нөөцийг зохицуулах гэх мэт арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгааг анхаарвал зохино.

3.1. Манай улсын гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн нөхцөл байдлын үнэлгээнд дурдсан гэмт хэрэг, зөрчилд орж болзошгүй хараа хяналтгүй хүүхдүүдтэй ажиллах богино болон дунд хугацааны практик арга хэмжээг хэрэгжүүлэхэд "багаар" төвлөрөн ажиллах тогтолцооны чиг хандлагыг бий болгон хөгжүүлэх хэрэгцээ байна. Ингэхдээ хүүхдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ рүү хандах нь чухал юм. Эндээс зарим арга хэмжээг дурьдвал:

- Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй хүүхдүүдийг цагдаагийн хяналтанд авдаг практикийг зогсоож үүний оронд эрсдэлтэй хүүхдүүдэд\хараа хяналтгүй, хүчирхийлэлд өртсөн, зүй бусаар ашиглагдсан зэрэг\ нийгмийн ажилтан үнэлгээ хийх, холбогдох улсын болон олон нийтийн байгууллагын тусламж дэмжлэгийг үзүүлэхэд чиглэх нь зүйтэй. Хүүхдүүд болон тэдний эцэг эх байнгын дэмжлэг туслалцаа авах боломжийг баталгаажуулахын тулд хүүхдүүдийг сургуульд хамруулах эсвэл албан бус боловсрол олгох, амьдрах ухаан ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт оролцуулах, сайн эцэг эх байх чадвар эзэмшүүлэх, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаанд хамруулах, энгийн ойлгомжтой удирдамж журам, зөвлөмж зэргийг боловсруулах шаардлагатай байна.
- Халамжийн төвд шинээр ирсэн хүүхдийг том хүүхдийн дарамтлал, ашиглан мөлжих явдлаас сэргийлэх арга хэмжээ авах



3.2. Улс хот дүүрэг, хорооны түвшинд байгууллага хоорондын болон гадаад дотоодын ТББ - уудын уялдаа холбоо, түншлэлийг өргөтгөн бэхжүүлэхэд чиглэсэн, хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлтэй хүүхдийн талаарх нийтлэг-стратегийн бодлого, зорилтыг тодорхойлох нэн тэргүүнд шаардлагатай байна.

3.3. Хүүхдийг хамгаалах, халамжлах бодлого, үйл ажиллагааг хүүхэд гэр бүлийн нийгмийн хамгааллын шинэчлэлтэй хослуулан хийх шаардлагатай байна. Энэхүү шинэчлэл нь гэр бүлийн дотор болон гадуур хүчирхийлэл мөлжлөгт өртөн зүй бусаар ашиглуулж байгаа хүүхдэд илүү өргөн хүрээтэй асуудалтай холбоотой юм. Гэхдээ энэ асуудлыг авч үзэхдээ өнөөгийн нийгэмд байгаа баян ядуугийн ялгаа, завхрал, эцгийн эрхт ёс, жендэр гэх мэт олон талт асуудлуудыг харгалзан үзэхгүй бол биеллээ олохоосоо хямралд хүргэж болзошгүйг анхааран үзэх хэрэгтэй.³³

3.4. Хүүхдийн эрхийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс хүүхдийн асуудал, эдийн засаг, нийгмийн хамгааллын шинэчлэлийн урьдчилсан нөхцөл болох хүүхдийн нийгмийн хамгааллын шинэчлэлийн харилцан шүтэлцээтэй, нийтлэг, нэгдсэн үзэл баримтлал, салбар хоорондын үр дүнтэй ажиллагаа нэн шаардлагатай байна.

3.5. Засгийн Газрын төсвийн чадавхид бодитойгоор хандах юм бол халамж үйлчилгээний оновчтой тогтолцоо нэвтрүүлэх замаар одоо байгаа нөөцөө бэхжүүлж, илүү үр дүнтэй, бүрэн дүүрэн ашиглах явдал чухал юм.

3.6. Асуудлыг үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэх ажилд далайцтай орох шаардлагатай байна. Энэ нь нийгэм эдийн засгийн хувьд үр ашигтай шийдэл болдог.

3.7. Нэгэнт хүнд хэцүү байдалд орчихоод хүүхдэд нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэхдээ богино болон дунд хугацааны үйлчилгээ үзүүлэх салбар дундын оролцооны уялдаа холбоог сайжруулах нь ээлтэй орчин бүрдүүлэхэд чухал нөлөө бүхий тогтолцооны удирдамжаар хангах, тодорхой арга хэмжээг урьдчилан авах нь зүйтэй:

- Хүүхдийн зан төлөв, аюулгүй байдал, хөгжилд эцэг эх нь аюул учруулж байгаа гэр бүлийн дотоод нөхцөл байдлаас хүүхдийн эрхийг хамгаалах, мөн гэр бүлээс гадуур хүчирхийлэл, мөлжлөг, хүүхдийг зүй бусаар ашиглах явдалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үүнтэй холбоотой нийгмийн ажлын лавлагаа тайлан, нотлох баримт, мэдэгдэл гаргах үйл явцыг хялбарчлах журам, механизм бүрдүүлэх шаардлагатай.
- Хүүхэд гэр бүлээсээ хөндийрөх, халамжийн байгууллагад ирэхээс урьдчилан сэргийлсэн үр дүнтэй "хаалга барих" бодлого, үйл ажиллагаа явуулах,
- Хүүхдийн эрхийн Конвенцийн хүүхэд, гэр бүлийн талаар явуулах бодлого, заалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг бүх шатанд гүнзгий ойлгуулах, төвлөрлийг сааруулах,

³³ ХЭҮТ –ийн "хүүхэд хамгаллын нэгжийн үнэлгээ В.Гучеран 2004



3.8.Халамжийн төвийн үйл ажиллагаа нь зөвхөн хүүхдийг гудамжинд гарахаас хамгаалах биш, тэдэнд нийгмийн чанартай, тухайн хүүхдийн хэрэгцээнд төхирсон үйлчилгээ үзүүлж, тэднийг гэр бүлд нь амжилттай буцаахад чиглэгдэх ёстой билээ. Эдгээр хүүхдүүдэд хоноглох байр, идэх хоолноос гадна нийгэмд хөлөө олох, амьдрах арга ухаанд суралцах, сурсан муу зуршлаасаа салах сэдлийг төрүүлж, 6 - 24 сарын турш зан үйл өөрчлөх, төлөвшүүлэх урт хугацааны нийгэм сэтгэл заслын сургалтуудын мэргэжлийн түвшинд явуулах мэргэшлийн ур чадварыг тус төвийн нийгмийн ажилтан сэтгэлзүйч нарт эзэмшүүлэх,

3.9.Бүхий л үйл ажиллагаа хүүхдийг гэртээ буцан харьж, хэвийн амьдрахад чиглэгдэж, гэр бүлийнхэнтэй нь нягт холбоотой ажиллан тэндэнд тусгамдсан асуудалд нь үнэлгээ хийж, тэдний хэрэгцээ, эрхэд суурилсан үйлчилгээ үзүүлж, хүүхэд, эцэг эхийн харилцааг эрүүлжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллах тогтолцоонд шилжихгүй бол бид хараа хяналтгүй хүүхдийн "урсгалын эргүүлэг"-нээс гарах боломжгүй юм.

3.10.Халамжийн төвүүдийн хангалт, үйлчилгээний асуудлыг гэр бүлд чиглэсэн нийгмийн бодлого хангамжийн дагуу гэр бүлийн дотор дэмжлэг үзүүлэх, төвлөрсөн байгууллагын орчноос татгалзан, Хүүхдийн эрхийн Конвенцийн зарчимд тулгуурлан өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай байна.

3.11.Гудамжинд байнга амьдардаг болон шинээр гарч ирсэн гэгдэх хүүхдүүдэд шаардлагатай дэмжлэг туслалцааг тогтмол үзүүлэх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэн тэднийг хэвийн амьдралд буцаан оруулах, нөхөн сэргээх боломжтой юм. Энэ үйлчилгээг хоёр түвшинд хийх боломжтой:

- Урьдчилан сэргийлэх дэмжлэг туслалцааг гудамжинд шинээр гарсан хүүхдэд үр дүнтэй үзүүлэх
- Урт хугацаагаар гудамжинд амьдарсан хараа хяналтгүй хүүхдүүдэд ганцаарчлан тулж ажиллан нийгмийн амьдралд буцаан оруулахад салбар дундын оролцооны чадавхийг бий болгох

Хүүхэд ойрын ирээдүйд гэртээ очих боломжгүй ч хүүхэд, гэр бүлийн харьцааг хадгалах, гэрт нь "буцаах" боломжийг хөхүүлэн дэмжих нь туйлын чухал юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ХАВСРАЛТЫН ТОВЬЁОГ

Хавсралт 1. Сурвалжлагын судалгааны асуултууд

Хавсралт 2. Хүүхдийн эсрэг хүчирхнйлэл бодлого хөтөлбөрт тусгасан байдал

Хавсралт 3. Хүүхдийн эсрэг хүчирхийлийн илрэл, кейсүүд

Хавсралт 4. Хүүхдийн хаяг тогтоох шалган хуваарилах төвийн анкет

Хавсралт 5. Гэмтэл согогийн сэргээн засах клиникийн анкет

Хавсралт 6. Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвийн үнэлгээний асуулга

Хавсралт 7. Ашигласан материал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Хавсралт 1. Сурвалжлагын судалгааны асуултууд

А. Төрийн байгууллагын ажилтнуудад зориулав

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрхзүйн орчин ямар түвшинд байна вэ ? Тусгайлсан дүрэм журмууд бий эсэх ,
2. Энэ зохицуулалт нь хүүхдийн өргөдөл гомдлыг барагдуулахад хэр зэрэг хэрэгжиж байна вэ ?
3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархац манай улсад ямар байна вэ ? Энэ баримтыг статистик судалгаагаар гарах уу ?
4. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд ямар байдлаар илэрч байна вэ ?
5. Хүүхдийн хүчирхийллээс хамгаалах нийгмийн ажлын ямар тогтолцоо байна вэ ?
Энэ тогтолцоо нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалж чадаж байна уу ?
6. Гэмт хэргийн золиос болсон, гэмт хэрэгт холблогдсон, хараа хяналтгүй хүүхдүүдийн гэр бүлтэй нь хэрхэн ажиллаж байна вэ ?
7. Хүүхдийг амьдрах ухаанд төлөвшүүлэх нийгмийн ажлын аргагүй ямар түвшинд явагдаж байна вэ ?
8. Төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүүхдүүдийн бичиг баримтын бүрдэлтийн байдал ямар байдаг вэ ?
9. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх вэ ? Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах ямар арга хэмжээ авч байна вэ ?

Б. Төрийн бус байгууллагын ажилтнуудад зориулав.

1. Өнөөдөр сургууль завсардсан, хараа хяналтгүй, гудамжны тэмэнэл хүүхдийн тоо буурахгүй байгааг та юу гэж үзэж байна вэ ?
2. Өнөөдөр хүүхдийн хүмүүжил, сахилга бат ямар хэмжээнд байна гэж үзэж байна вэ ? Та энэ талаар юу гэж бодож байна вэ ? Хэрэв анхаарал татсан асуудал гэж үзэж байгаа бол яаж сайжруулах вэ ?
3. Хүүхэд хүчирхийлэл дарамтанд өртөж байна уу , тийм бол ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ ?



4. Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй хэрхэн ажиллаж байна вэ ? үйл ажиллагааг тогтвортой явуулж чаддаг уу , ямар бэрхшээл учирдаг вэ ?
5. Төрийн байгууллагатай яаж хамтарч ажиллаж байна вэ ?
6. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх вэ ?

В. Эцэг эхчүүдэд зориулав .

1. Та хэдэн хүүхэдтэй вэ ? Ямар насны хүүхдүүдтэй вэ ?
2. Танай хүүхэд хичээлээ тухтай хийх боломжтой юу ?
3. Хэрэв суралцах боломжгүй бол яагаад ?
4. Танай хүүхэд биеийн эрүүл мэндийн хувьд ямар вэ ?
5. Танай харьяаны эмч, эмнэлгийн эмч нар хүүхдэд тавих анхаарал ямар вэ ?
6. Танай гэр бүлийн гишүүд болон хүүхдүүд бичиг баримтын зөрчилтэй юу ?
7. Танай хүүхэд чөлөөт цагаа хаана хэрэхэн өнгөрүүлдэг вэ ?
8. Хүүхдийн хүмүүжилд гэр бүл онцгой үүрэг хүлээх үү эсвэл сургууль уу ?
9. Танай хүүхэд ихэвчлэн юунаас болж, уцаарлаж, эсвэл сэтгэл санааны тавгүй байдал ордог вэ ?
10. Танай гэр бүл эвсэг нээлттэй таатай уур амьсгалтай байж чаддаг уу ?
11. Хүүхдийн талаар таны сэтгэлийг хамгийн их зовоож буй асуудал юу вэ ?

Г. Багш сурган хүмүүжүүлэгчдэд зориулав.

1. Өнөөгийн боловсролын агуулга хүүхдийн нас насны хэрэгцээнд нийцэж байна уу ?
2. Сургууль дээр хүүхдийн эсрэг хүчирхийлэл хэр зэрэг илэрдэг вэ ?
3. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалахын тулд сургуулийн орчинд ямар арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй гэж үзэж байна вэ ?



4. Хүүхдийг амьдрах ухаанд сургах ямар сургалт хүмүүжлийн ажил явагддаг вэ ? Та энэ ажлыг зохих түвшинд явагддаг гэж үзэж байна уу ?
5. Ангийн багш нар хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн амьдрал, харилцааны нөхцөл байдлын хэр мэддэг вэ , хэрхэн эцэг эхтэй нь холбоотой ажилладаг вэ ?
6. Сургуулийн нийгмийн ажилтны ажлыг хэр зэрэг дэмждэг вэ ? Хүүхэдтэй ажиллах нийгмийн ажлын чиглэлээр бодитой өөрчлөлт гарч байна уу ?
7. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалахын тулд сургуудийн орчинд нэн тэргүүнд ямар өөрчлөлтийг хийх хэрэгтэй гэж та үзэж байна вэ ?

Д.Хүүхдэд зориулсан Фокус бүлгийн ярилцлагын асуулга

1. Гэр бүлийнхээ харилцааг юу гэж үздэг вэ ? чамд таалагддаг уу ? үгүй бол ямар байгаасай гэж хүсдэг вэ ?
2. Сургууль дээр багш сурагчид бие биенээ хэрхэн хүндэлдэг вэ ?
3. Сургууль дээр үе тэнгийнхэнтэйгээ харилцахад бэрхшээл учирдаг уу тийм бол ямар ?
4. Чөлөөт цагаа хаана хэнтэй ихэвчлэн өнгөөрдөг вэ ?
5. Өөрт хэрэгцээтэй мэдээллийн хаанаас олж авдаг вэ ? Ямар мэдээллийг чухал гэж үздэг вэ ?
6. Биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэл өртөх тохиолдолд хэн нэгнээс тусламж дэмжлэг хүсдэг үү , хэнээс ?
7. Хүчирхийлэл хаана илүү өртөх магадлалтай байдаг гэж та үзэж байна вэ ?

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



Хавсралт 3 : Хүчирхийллийн илрэх хэлбэрүүдийн баримтаас

1. Үл тоомсорлох буюу шоовдорлох хэлбэрийн хүчирхийлэл :

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг асран хамгаалах ёстой үүргээ гүйцэтгэхгүй, ухамсарлахгүй байгаагаар илэрнэ. Өөрөөр хэлбэл хүүхдийн оюун ухаан, бие бялдрын хөгжил, эрүүл мэндийг хамгаалах зэрэгт авах ёстой арга хэмжээнүүдийг авахгүй, хайхрамжгүй хандлага гаргаж байгаа явдал орно.

Иргэн Б нь 2 дагавар охинтой О-той сууснаас хойш 2 жилийн дараа өөрийнх нь охин нь А нь төрсөн. Үүнээс хойш 2 дагавар охиноо ад үзэж, гэр орноосоо хөөн, эхнэрээ хүүхдүүдээ өмөөрөхөөр зоддог. Хичээл сургууль, болон наад захын хэрэгцээг хангах ямар ч арга хэмжээ авдаггүйгээс шалтгаалан одоо 14 – 16 насны 2 охин ээжийнхээ төрсөн дүү нар дээр тус тусдаа амьдардаг.

ХЭҮТ-д байрлаж байсан 16 настай охин У-ийн ярианаас

2. Асран хамгаалагчгүй орхих : Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдээ харж асрах хүнгүйгээр янз бүрийн хугацаагаар гэрт нь орхих явдлыг хэлнэ. Үүнийг “Гэртээ ганцаараа үлдэх тохиолдол” гэж нэрлэх бөгөөд хүүхэд тодорхой асрамж хамгаалалтгүй үлдэхийг хэлнэ.

Б 13 настай, дүү Б нь 11 настай. 2 жилийн өмнө тэдний эцэг эх нь Солонгост ажиллахаар явахдаа авга эгч Э-ийн асрамжинд 2 охиноо үлдээгээд явсан. Ах эгч 2-ыг ажилдаа явсан хойгуур тэдний төрсөн хүү болох 17 настай Э 2 охиныг хүчинддэг байжээ...

ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчийн бүртгэлээс 2003 он

3. Бие махбодийн хүчирхийлэл: Хэн нэгэн / насанд хүрэгчид болон үе тэнгийнхэн / өөрийн давуу талаа ашиглан, хүч хэрэглэж, хүүхдийн бие махбодийг өвтгөх, улмаар гэмтэл учруулах, эрүүл мэнд, амь насанд нь аюул занал учруулсан, эсхүл учруулж болзошгүй үйлдлүүдийг хэлдэг. Энэ тохиолдолд хүүхэд өөрийгөө хамгаалах ямар ч арга хэмжээг авч чаддаггүй.



*Аав намайг долоо хоногт 2-3 удаа зоддог. Эхлээд ээжийг зодно, дараа нь намайг...
Аавдаа зодуулж, эмнэлэгт хэвтэж, томсогний хагалгаанд орсон.*

10 настай хүү³⁴

4. **Сэтгэл санааны хүчирхийлэл:** Хүүхдийн өөрийн үнэлэмж, сэтгэл санааны хөгжилд сөргөөр нөлөөлөхүйц үг хэллэг хэрэглэж хүүхдийг доромжлох, нэр хоч өгөх, гутаах, айлган сүрдүүлэх, хэрээс нь хэтэрсэн зүйлийг шаардах, ялгаварлан гадуурхах, үл ойшоох, ганцаардуулах, урам өгөхгүй байх зэрэг сэтгэл зүйн хэрэгцээг хүчээр боогдуулсан аливаа үйлдлүүдийг хэлнэ.

Аав надад гар хүрдэггүй ч байнга дорд үзэж, чи юу чаддаг юм, боль, байж байгаа царайг нь эхийгээ дуурайсан хэнэггүй гөлөг, миний нүдэнд бүү харагд, үхээд өгөөсэй гэж хөдлөх, харах тоолонд маш муухай үгээр харааж загнадаг. Би түүний дэргэд юу ч хийж чаддаггүй, хурдан том болоод энэ гэрээс явчих юмсан гэж үргэлж боддог болсон.

11 настай хүү

5. **Бэлгийн харилцааны хүчирхийлэл:** Хэн нэгэн бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн итгэлийг эвдэн хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, албадах, хүч түрэмгийлэх арга хэрэглэж шууд ба шууд бус замаар бэлгийн ямар нэгэн төрлийн харилцаанд татан оруулсан үйлдлийг хэлнэ. Үүнд зөвхөн бэлгийн харилцаанд орсон тохиолдлуудаас гадна завдах үйлдлүүд болон садар самуун – порнографид татан оруулсан үйлдэл, эс үйлдлүүдийг хамааруулдаг.

Авга ах нь 10 настайгаас нь эхлэн эцэг эхийг нь байхгүйд бэлгийн харилцааны зорилгоор биеийн нууцлаг, эмзэг хэсгүүдэд хүрэх, илж таалах, үнсэхийг оролддог. Энэ тухай хэнд ч хэлэхгүй байхыг сануулж, хэрэв хэлбэл ална хэмээн сүрдүүлдэг байсан. Хамгийн сүүлд гэрт нь хүнгүй байхад орж ирээд хүчиндэхийг завдах үед ээж нь орж ирж салгаж, цагдаад хандсан.

14 настай охин

Хүчирхийллийн дээрх хэлбэрүүдийн аль аль нь хүүхдийн бие махбод, сэтгэл санааны хөгжилд сөргөөр нөлөөлж, ноцтой гэмтэл учруулж, зарим тохиолдолд үхэлд хүргэх аюултай.

³⁴ Хүүхэд эмзэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар 2004 он УБ хот



Хүчирхийллийн харилцаатай гэр бүлд хүүхэд золиос болж хохирдог.

Гэр бүлийн хүчирхийллийн золиос нь хүүхэд болдог гэдгийг доорхи баримтууд харуулж байна. Үүнд:

- *Хүүхэд эцэг эхийн хоорондын тэмцлийг болиулахын тулд тэдний гарт өртөж, биеийн хүчний, сэтгэл санааны тэр ч байтугай үл хайхрах шоовдорлох хэлбэрийн хүчирхийлэлд ортдог.*

Бодит баримт:

Ээж О, хойд эцэг А-ийн хамт амьдардаг. Хойд эцэг А нь байнга архи ууж ирээд, ээжийг нь зоддог. Б ээжийгээ өмөөрч тэр 2-ыг салгахыг оролдож олон удаа эцэгтээ алгадуулж, цохиулж, өшиглүүлэн биедээ хөхрөлт, няцралт авч байсан ба нэг удаа эцэг нь ээж рүү нь хутга барьж, ална хэмээн дайрахад нь дундуур нь ортол гуяндаа хутгалуулсан. Одоо тэр гэрээсээ дайжин, нэгэн халамжийн төвд амьдарч байгаа...

Охин Б 15 настай.



Хавсралт 7 : Ашигласан материал

- Хүүхдийн эрхийн конвенц /1989/
- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын удирдамж /Риядын үндсэн чиглэл/ /1990 он/
- Монгол улсын Эрүүгийн хууль /шинэчлэгдсэн/
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хууль
- Цагдаагийн байгууллагын тухай Монгол улсын хууль /1993 он/
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хууль /1996 он/
- Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай Монгол улсын хууль /1994 он/
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль /1999/
- Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр 2002-2010 /УБ 2002/
- Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн байдлын үнэлгээ НҮБ-ын хүүхдийн сан 2000
- Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг үнэлэх судалгааны тайлан 2000
- Хүүхдийн биеэ үнэлэх явдлын мөн чанар, чиг хандлага ба олон нийтийн дундах үзэл бодлын талаарх судалгааны тайлан , МУИС-ийн хүн амын сургалт судалгааны хүрээлэн 2001
- Монголын нийгмийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх тухай азийн хөгжлийн банкны тайлан 2002 оны 9 дүгээр сар/
- Нийгмийн хамгааллын мастер төлөвлөгөөний тухай Азийн хөгжлийн банкны тайлан 2003
- Монголд өсвөр үеийнхнийг шүүхэд татаж байгаа нь НҮБ-ын хүүхдийн сан /2002/
- Нийгмийн ажлын чанарыг сайжруулах төслийн явцад өгсөн үнэлгээ Английн хүүхдийг ивээх сан 2004
- Монгол дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон хуулийн зохицуулалт НҮБ-ын эмэгтэйчүүдийн сан.
- Гудамжны хүүхдүүдийг иргэний нийгэмд буцаан нэгтгэх нь Дэлхийн банкны төслийн тайлан /2002 оны 4 сар/
- Гудамжны болон хаягдсан хүүхдүүдийн судалгаа Хүүхдийн төлөө үндэсний төв НҮБ-ын Хүүхдийн сан /2003он/
- Хараа хяналтгүй хүүхдүүд Гучаран Вирдее НҮБ-ын Хүүхдийн сан /2003 он/
- Хүүхдийн хамгаалал Монголмаа НҮБ-ын Хүүхдийн сан /2005 он эх ноорог/